

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7 – 48

1. *Байнгын хорооноос хийх төлөвлөгөөт хянат шалгалтын саналыг хэлэлцэх*

8 – 48

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы  
Өргөдлийн байнгын хорооны 12 дугаар сарын 24-ний өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 59 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.*

*Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, П.Мөнхтулга;  
Чөлөөтэй: Д.Батбаяр, Х.Баттулга, Б.Батцэцэг, Б.Пунсалмаа,  
Ч.Ундрэм, С.Цэнгүүн;  
Эмнэлгийн чөлөөтэй: Р.Эрдэнэбүрэн;  
Тасалсан: Ж.Батсуурь, С.Ганбаатар.*

**Нэг.Байнгын хорооноос хийх төлөвлөгөөт хянат шалгалтын саналыг хэлэлцэх**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт С.Уянга, Г.Нямсүрэн, ажилтан Д.Оюун нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгах саналаа Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат танилцуулав.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**О.Номинчимэг:** Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт, цахилгаан дулааны станц, зам, нүүрс тээвэрлэлт, бензин шатахуун, ахуйн газ зэрэг аюултай ачаа бараа тээвэрлэлтийн хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл байдалд хяналт шалгалт хийх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 5  
Бүгд: 14

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгах саналаа Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хариулж, тайлбар хийв.

**О.Номинчимэг: 1.**Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах үр дагавар бүхий хууль тогтоомжийн үр дагаврын үнэлгээ хийх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 5  
Бүгд: 14  
64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**2.**Хууль тогтоомжийн хүрээнд хүний хөгжих эрхийг хязгаарлах үр дагавар үүсгэж болзошгүй зарим хуулиудын үр дагаврын үнэлгээ хийх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 5  
Бүгд: 14  
64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**3.**Хууль тогтоомжийн давхардлыг арилгах хүрээнд Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалт нь Цагдаагийн албаны тухай, Прокурорын тухай, Авлигын эсрэг хууль болон Сэжигтэн, яллагдагчийг баривчлах тухай хуульд давхардуулан зохицуулсан зарим зохицуулалтад үр дагаврын үнэлгээ хийх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 5  
Бүгд: 14  
64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгах саналаа Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун танилцуулав.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, Л.Мөнхбаясгалан, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун хариулж, тайлбар хийв.

**О.Номинчимэг:** 1.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн үр дагаврын үнэлгээ хийх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 7  
Бүгд: 14  
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Төв суурин газар, аймаг, нийслэлийн ундны усны хэрэглээ, хөрсний бохирдол, түүнээс шалтгаалсан өвчлөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар тайлан мэдээлэл сонсох, хяналт шалгалт хийх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 6  
Бүгд: 14  
57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Хог хаягдлын тухай, Эрүүл ахуйн тухай, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тайлан, мэдээлэл сонсох, хяналт шалгалт хийх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 6  
Бүгд: 14  
57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, Хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж байгаа үйл ажиллагааны талаар мэдээлэл сонсох, тайлан илтгэл хэлэлцэх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 6  
Бүгд: 14  
57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Эрүүл мэндийг дэмжих сантай холбоотой хуулийн хэрэгжилтийн талаар үр дагаврын үнэлгээ, хяналт шалгалт хийх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

---

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 7  
Бүгд: 14  
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгах саналаа Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах танилцуулав.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, Г.Лувсанжамц, С.Замира, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах хариулж, тайлбар хийв.

**О.Номинчимэг:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын гаргасан, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулах, тайлан мэдээлэл сонсох саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 5  
Бүгд: 14  
64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**2.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 6  
Бүгд: 14  
57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгах саналаа Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулав.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ц.Мөнхтуяа, С.Эрдэнэбат, С.Замира, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хариулж, тайлбар хийв.

**О.Номинчимэг:** 1.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Орон сууц захиалах, худалдан авах харилцаан дахь хууль тогтоомжийн хэрэгжилтийн нөхцөл байдлын талаар ажлын хэсэг байгуулж, тайлан мэдээлэл

сонсож, хэлэлцүүлэг хийх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Өргөдлийн байнгын хорооноос Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийгдэх төлөвлөгөөт хянан шалгалтын цаглаварт тусгуулах саналыг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 31 минут үргэлжилж, 24 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 30 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, Лхагва гараг  
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим  
12 цаг 59 минут

### ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**О.Номинчимэг:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирсэн, Хажекберийн Жангабыл гишүүн ирсэн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн, Одсүрэнгийн Номинчимэг ирсэн, Мягмардашийн Сарнай гишүүн ирсэн, Жанчивын Галбадрах гишүүн ирсэн, Сонгобайн Замира гишүүн ирсэн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн, Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ирсэн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн, Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн, Цэндсүрэнгийнгийн Мөнхтуяа гишүүн ирсэн, Отгоны Саранчулуун гишүүн ирсэн, Далайн Батбаяр гишүүн чөлөөтэй, Халтмаагийн Баттулга гишүүн чөлөөтэй, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гадаад томилолттой, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн чөлөөтэй, Чинбатын Ундрам гишүүн чөлөөтэй, Засгийн газрын хуралд байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн өвчний чөлөөтэй, Саруулсайханы Цэнгүүн гишүүн чөлөөтэй гэсэн ийм ирцтэй байна.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хурал хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Өнөөдөр нэг л асуудал байгаа. Энэ өмнө нь Өргөдлийн байнгын хороо шинэ тутам байгуулагдаж ер нь Байнгын хорооны чиг үүргийг бид яаж илүү дорвитой сайжруулж, байнгын ажиллагаатай Байнгын хорооны түвшинд аваа вэ гэдэг асуудал дээр гишүүдтэйгээ санал солилцож, асуудлуудаа нэлээн сайн ярилцсаны үндсэн дээр хийе гээд энэ асуудлыг оруулж ирж байгаа.



Энэ Байнгын хорооноос хийх төлөвлөгөөт хянан шалгалтын саналыг хэлэлцэх тухай байгаа.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хороо дараагийн ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хянан шалгалтын цаглаварт тусгуулах саналаа Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлдэг.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын хувьд бусад мэргэжлийн Байнгын хороо өөрийн гэсэн салбарын чиглэлтэй, түүн дээрээ төлөвлөгөө гаргадаг. Хяналт шалгалтын тухай хуулиар жил болгон тайлагнадаг, хуулийн асуудлуудтай байдаг.

Өргөдлийн байнгын хорооны хувьд энэ шинээр байгуулагдсан. Энэ хүрээндээ яг өөрийн чиглэлийн салбар гэж байхгүй. Иргэдээс ирж байгаа өргөдөл, гомдол дээр тулгуурлаж бид ер нь бодлогын түвшинд иргэдээс юу дутагдаж хүсээд байна, бодлогын хийдлүүд юу байна, үүнийг гаргаж ирж санал, зөвлөмжүүдээ гаргадаг. Үүнийг иргэддээ тайлагнадаг чиг үүрэгтэй байгаа.

Өмнө нь төлөвлөгөөт хяналт шалгалтыг бусад Байнгын хороодоос ерөнхийдөө албан бичгээр өгдөг байсан боловч бид энэ удаа Өргөдлийн байнгын хорооны хувьд ийм онцлогтой Байнгын хороо учраас хэрвээ хаврын чуулганаар хийх гэж байгаа хяналт шалгалтын ажлуудаа хоорондоо маш сайн хэлэлцэж, уялдаатай байж, үнэхээр хийдэл, асуудлууд байна уу, иргэдээс маань ямар санал санаачилга гарч байна, түүнд нийцэж байна уу гэдэг байдлаар хэлэлцэж өнөөдөр саналаа хураая гэсэн байдлаар оруулж ирж байгаа гэдгийг Та бүхэндээ хэлье.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс саналтай гишүүн байна уу? Алга байна.

Санал байхгүй учраас хэлэлцэх асуудалдаа оръё.

---

### **Нэг.Байнгын хорооноос хийх төлөвлөгөөт хянат шалгалтын саналыг хэлэлцэх**

---

Ерөнхийдөө Өргөдлийн байнгын хороон дээр Та бүхэнд хоёр долоо хоног тутам Байнгын хорооны ажлын албанаас ирж байгаа өргөдөл, гомдлын агуулга салбар асуудлуудыг тоон дата гаргаж хүргүүлж байгаа.

Та бүхэн харах юм ерөнхийдөө

- “төрийн үйл ажиллагаа”,
  - “хүний эрх”,
-

— “засаглал”-тай холбоотой асуудал маш их орж ирж байгаа.

Сүүлийн үед Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороон дээр ирсэн хувь хүний өргөдөл, гомдол, хүний эрхийг зөрчсөн асуудлыг ч гэсэн Өргөдлийн байнгын хороо шилжүүлдэг болоод байгаа.

Тэр нэгдүгээр асуудал байна.

Цалин, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн асуудалтай холбоотой асуудал их өндөр байгаа.

Мөн хот байгуулалт, стандарттай холбоотой асуудлууд орж байна.

Бид өмнөх Байнгын хороон дээрээ ярилцсан. Эрхлэх асуудлын хүрээнд биш буюу харьяаллын бус төрийн шагналд тодорхойлуулах хүсэлт ч байдаг юм уу, шагнал урамшуулал авах асуудал. Энэ асуудлыг Өргөдлийн байнгын хороо авахгүй. Бид илүү бодлогын түвшинд иргэдийнхээ хүсэл эрмэлзэл, санал нь юун дээр байна, бодлогын түвшинд хийх ажлууд юу байна гэдгийг илүү сайн мэдэрч ажиллах ёстой гэж байгаа.

Тэр хүрээндээ Улсын Их Хурал –

- Нэгдүгээрт, хууль тогтоох чиг үүрэгтэй.
- Хоёрдугаарт, хянан шалгах, гүйцэтгэх засаглалаа хянах чиг үүрэгтэй.
- Гуравдугаарт, төлөөллийн байгууллага, иргэдээ төлөөлөх үүрэгтэй.

Энэ хүрээндээ мэдээж хууль тогтоох асуудал салбарын мэргэжлийн Байнгын хороодуудаар нэлээн явдаг. Гэхдээ хууль тогтоогоод гарсан хуулиуд маань цагаан цаасан дээр хар болоод амьгүй үлддэг хуулиуд маш их байдаг.

Үнэхээр хууль хэрэгжилтийн асуудал амьдрал дээр үнэхээр бууж байна уу, үр дүн гарч байна уу гэдэг асуудал хамгийн чухал асуудал болоод байна. Бид нарын анхаарах.

Мэргэжлийн Байнгын хороод дээр харахад ер нь хяналт шалгалтын ажил яах вэ, сонсгол явлаа. Тийм ээ. Сонсгол хамгийн онцгой нэг хэлбэр. Гэхдээ байнга салбарын хуулиудын хэрэгжилтийг юун дээр доголдож байна, асуудал байна уу гэдгийг хянаж байх ёстой. Байнгын хороод дээр явж байгаа асуудлыг харахаар тэр болгон байхгүй. Хууль тогтоох чиг үүргийн асуудлууд их байна.

Тэгэхээр манай Байнгын хороон дээр ирж байгаа асуудлууд ер нь хүний эрхийг зөрчиж байгаа, хууль хэрэгжилтийн асуудлуудтай холбоотой байгаа учраас хаврын чуулганы үеэр Өргөдлийн байнгын хороо далайцтай хууль, эрх

зүйн хэрэгжилтийн асуудал дээр анхааръя гэсэн саналтай байгаа юм. Үүнийг даргын дэргэдэх зөвлөл дээр ч гэсэн би танилцуулсан.

Мэдээж ингэхдээ мэргэжлийн Байнгын хорооны асуудлыг урдуур нь орж авч хийнэ гэсэн үг биш. Иргэдээс санал хүсэлт гарч байгаа, бодлогын хийдэл гараад байгаа, энэ дээр асуудал байна шүү гэж Өргөдлийн байнгын хорооны гишүүд Та бүхэнд ирж байгаа санал, нийгмийн сүлжээнд болон бусад иргэдээс гаргаж байгаа саналууд дээр үндэслэж цөмөөрөө хяналт шалгалтын тулгамдаад байгаа асуудлууд юу байна гэдгээ өнөөдөр хоорондоо сайтар хэлэлцээд, саналаа хурааж, саналаа Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэхээр байгаа юм шүү гэдгийг хэлье.

Ингээд Өргөдлийн байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгуулахаар Байнгын хорооны гишүүдээс ирүүлсэн саналыг хэлэлцэж эхэлье.

Байнгын хороонд Өргөдлийн байнгын хорооны гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат, Хүрэлбаатарын Баасанжаргал, Ганзоригийн Лувсанжамц, Отгоны Саранчулуун, Одсүрэнгийн Номинчимэг, Ж.Галбадрах гишүүн нараас санал ирүүлж нэлээдгүй хугацаанд хоорондоо сая ярилцах шиг боллоо. Тийм ээ. Гишүүдийн групп дээр ч гэсэн саналууд их явж байна.

Ингээд ирүүлсэн дарааллаар цөмөөрөө саналуудаа ярилцаад санал хураалтаа явуулъя гэж бодож байна.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбатаас ирүүлсэн санал.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүнээс хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, түүний дотор дулаан болон эрчим хүчний цахилгааны станцуудын аюулгүй байдалд хяналт шалгалт хийх, зам, нүүрс тээвэрлэлт, бензин шатахуун, ахуйн газ зэрэг аюултай ачаа бараа тээвэрлэлтийн хөдөлмөрийн аюулгүй байдалд хяналт шалгалт хийх талаар санал ирүүлсэн байна.

Тэгэхээр дэгийн дагуу Сүхбаатар Эрдэнэбат гишүүн энэ саналаа ямар үндэслэлээр гаргаж байгаа гэдгээ тайлбарлаж хэлэх хэрэгтэй.

Иргэдээс ирж байгаа ямар саналууд байна, ямар асуудлууд байна, юун дээр үндэслэж хянан шалгалт хийх саналыг гаргаж байгаа гэдгээ Сүхбаатар Эрдэнэбат гишүүнийг саналаа тайлбарлаж өгөхийг урьж байна.

С.Эрдэнэбат гишүүний микрофон.

---

**С.Эрдэнэбат:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал дээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг оруулах зайлшгүй шаардлага байна.

Би хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын хэсгийг ахалж байх хугацаандаа иргэдтэй тодорхой кэйс дээр ажиллаад үзэхээр бид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, орчны эрсдэлтэй нөхцөл байдлыг гарсан үед нь осол аваар гарсан, хүний амь нас үрэгдсэн үед нь шуугиад өнгөрдөг байдлаар биш яг энэ эрсдэлд бид өөрсдөө бэлэн үү. Энэ бол хэн нэгэн мэргэжлийн хяналт гэдэг юм уу, тодорхой мэргэжлийн байгууллагын асуудал биш. Нийтээрээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд хэр зэрэг бэлэн байна вэ гээд.

Би ганцхан асуултыг хүмүүсээс мэргэжлийн дөрөв, таван байгууллагуудын дунд асуухад яг тодорхой хариу өгөөгүй.

Тэгээд энэ юуг харуулж байна вэ гэхээр бид аливаа эрсдэлд бэлэн биш байна. Тухайлбал, бид нарт хамгийн том сургамжтай асуудал. Яг түрүүн 2 жилийн өмнө байх. Газ дэлбэрсэн. Газтай машин явж байгаад машинтай мөргөлдөөд хөнгөхөн мөргөлдөхөд тэр газ нь алдагдаж түүнээс болж 4-өөс 5 хүн нас барсан. Төрийн албан хаагч нар амь насаа алдсан. Нэг бүхэл бүтэн орон сууц сүйдсэн.

Гэтэл тухайн үед байгаа амь насаа аврах бололцоотой байсан ямар зүйл байсан бэ гэхээр магадгүй өнөөдөр Улаанбаатар хотод бензин, шатахууны хомсдолтой үед өдрийн цагаар бензин, шатахуун, газ тээвэрлэхийг зөвшөөрсөн байгаа. Тасалдахгүйн үүднээс.

Нөгөө талд нь аюулгүй байдлынх нь асуудлыг бид өнөөдөр ямар байдалтай байгаа бол гэдэг зүйл дээр үнэлэлт дүгнэлт хийх хэрэгтэй юм байна. Маш олон хүмүүс газ хэрэглэдэг болсон байна.

Тийм учраас үүнийг дагасан хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг зүйлийг орхигдуулснаас болоод дахиад түүнээс ч илүү осол аваар гэмтэл гарах магадлал тун өндөр байна гэдэг үүднээс нь үүнийг шалгая, тодорхой мэргэжлийн байгууллагууд нь хяналт үнэлгээ дүгнэлт хийе гэдэг байдлаар тавьсан.

Иргэдээс асуухад магадгүй таны ойр орчинд газ алдагдсан байвал ямар дохио, ямар аюулгүй байдлыг мэдэх вэ гэдэг асуудалд бид хийх хэрэгтэй юм шиг байгаа юм.

Бидний хэлснээр ямар нэгэн аюултай ачаа тээвэрлэж байгаа машин дохио өгөх гэдэг юм уу, магадгүй Улаанбаатар хотын өдрийн түгжээний цагаар газ, бензин тээвэрлэж яваа машин осолдоод асгарсан тохиолдолд тэр чигээрээ

Улаанбаатар даяараа түгжээний цуваагаар шатах, дэлбэрэх маш том эрсдэл байна.

Үүнийг мэргэжлийн байгууллагууд ч гэсэн маш чухал ажил байна. Бид хамтраад дундаа хаяхгүйгээр асуудлыг шийдье гэдэг байдлаар оруулсан юм.

Замын цагдаагийн газар маш идэвхтэй санаачилгатай ажиллаж байгаа. Зам, тээврийн яам энэ тал дээр яг ний нуугүй хэлэхэд Зам, тээврийн яамны хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал хариуцдаг ямар хүн байдаг юм. Би маш хангалтгүй, ойлголтгүй байдал. Зам, тээврийн яам гэхээр нүүрс тээвэрлэлт, хот хоорондын тээвэрлэлт гэдэг юмыг л хариуцдаг юм шиг ойлгоод байдаг.

Гэтэл зам тээврийн осол аваараас болж хамгийн их хүн нас барсан тохиолдол маш их гардаг.

Станцуудын осол гарсан. Мөн ялгаа байхгүй бас эздийн аюулгүй байдлыг хангах шаардлага байгаа. Энэ өөрөө эргээд эдийн засгийн болон нийгмийн маш их том үр дагавартай учраас онцгойлон энэ салбарууд дээр хяналт шалгалт хийе гэдэг шаардлага байна гэдэг үүднээс үүнийг оруулсан юм.

**О.Номинчимэг:** С.Эрдэнэбат гишүүнд баярлалаа.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүний гаргасан саналтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Тодруулж асуух гишүүд нэлээн хоорондоо ярилцсан. С.Эрдэнэбат гишүүн үндэслэлээ сайн тайлбарлах шиг боллоо. Тийм ээ.

Ингээд асуулт асууж, үг хэлэх гишүүн байхгүй байна.

Тэгвэл С.Эрдэнэбат гишүүний цаглаварт оруулах саналаар цөмөөрөө санал хураалтад эхлээд бэлдье.

С.Эрдэнэбат гишүүний гаргасан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт, тэр дундаа цахилгаан дулааны станц, зам, нүүрс тээвэрлэлт, бензин шатахуун, ахуйн газ зэрэг аюултай ачаа бараа тээвэрлэлтийн хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл байдалд хяналт шалгалт хийх саналыг төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт оруулахаар дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Нийт 9 гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдлээ.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргалаас ирүүлсэн саналын талаар хэлэлцэнэ.

Х.Баасанжаргал гишүүнээс нийт 4 санал ирүүлсэн байгаа юм байна.

Тэгэхээр Х.Баасанжаргал гишүүн саналаа тайлбарлаж, ямар үндэслэлээр, мөн иргэдээс ирсэн өргөдөл, гомдол энд байгаа эсэх тал дээр тодорхой хэлнэ үү.

Х.Баасанжаргал гишүүний микрофоныг.

**Х.Баасанжаргал:** Улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж байгаа хууль тогтоомжууд манайд байгаа. Бид нарын өмнөх парламентын баталсан хэд хэдэн хуулиуд дээр зохицуулалтууд байгаа.

Үүний үр дагаврыг бид үнэлгээ хийх ёстой. Би жишээ татаад Биеийн тамир, спортын тухай хууль дээр улс төрийн үзэл бодлоо илэрхийлэхгүй, төвийг сахисан байх ёстой гээд ёс зүйн шаардлагыг бүх тамирчид, бүх дасгалжуулагч нарт тавьсан, бүр хуульчлаад өгсөн байгаа.

Гэтэл хүний үзэл бодолтой байх эрх чинь өөрөө огт хязгаарлаж болдоггүй Үндсэн хуулийн хэмжээний асуудал байгаа.

Тэгэхээр бид энэ мэтчилэн хуулиар улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарласан багагүй цогц үзүүлэлтүүд байгаа.

Тэгэхээр үүнд манай парламент манлайлах ёстой гэж харж байгаа. Тэр дундаа төрийн албаны тухай хууль, төрийн албанд ажиллаж байгаа олон хүмүүс улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх боломж байдаггүй.

Тэгэхээр энэ нөхцөл байдлыг бид яг бодитой бүрэн дүүрэн судалж үзэх ёстой гэж харж байгаа. Тэгээд ийм саналыг оруулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хувьд иргэн захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэл хамгийн муу байдаг. Ялангуяа захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл маш муу байдаг.

Энэ нь юу вэ гэвэл шүүх нь шийдээд байдаг.

- Төр нь биелүүлэхгүй байна гэсэн үг.
- Засгийн газар биелүүлэхгүй байна гэсэн үг. Шүүхийн шийдвэрийг.

Ийм өргөдөл манай Өргөдлийн байнгын хороон дээр орж ирсэн.

Тэгэхээр ийм зүйлүүдийг бид хянаж шалгаад, үүний хэрэгжилтийг сайжруулах дээр манай парламент манлайлал гаргаж ажиллаж байх ёстой гэдэг агуулгаар энэ саналыг оруулж ирж байгаа юм.

---

Хууль тогтоомжийн давхардал болон хөгжих эрхийн хязгаарлалтын хувьд ялангуяа эрүүгийн процесс болоод зөрчлийн процессын хуулиудаар бид хүний эрхийн стандартыг нэлээн өндөр тавьдаг хууль байгаа.

Гэтэл Цагдаагийн албаны тухай хууль, Авлигатай тэмцэх тухай хууль гээд өөр бусад салбарын хуулиудаар хүнийг саатуулах, хүнийг баривчлах зохицуулалтуудыг зохицуулсан. Мөрдөн шалгах нууц ажиллагаатай холбоотой зохицуулалтыг жишээ нь бусад салбарын хуулиудаар зохицуулсан явж байдаг.

Тэгэхээр энэ давхардлыг бид арилгаж хүний халдашгүй байх эрх чөлөөний асуудлыг эрүүгийн процесс, зөрчлийн процессын хуулиудаараа нэг мөр зохицуулах ажлыг манай парламент манлайлж хийх ёстой гээд энэ 4 саналыг гаргасан учраас гишүүдийг дэмжихийг хүсье.

Саналын томъёолол дээр байгаа хуулиудын нэрийг харин хасъя. Ганцхан энд дурдсан хуулиудаас гадна өөр бусад хууль тогтоомжууд байх учраас удирдамж дээрээ энэ тухай нарийн заагаад явъя.

- Улс төрийн эрхийн үзэл бодлоо илэрхийлэх,
- Хүний хөгжих эрх,
- Хууль тогтоомжийн давхардал, тэр дундаа хүний халдашгүй байдал,
- Шүүхийн шийдвэр биелдэг байх –

-гэдэг 4 агуулгын хүрээнд санал гаргасан. Дэмжихийг хүсье.

**О.Номинчимэг:** Х.Баасанжаргал гишүүнд баярлалаа.

Х.Баасанжаргал гишүүний гаргасан 4 саналтай холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн.

**Ц.Мөнхтуяа:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Х.Баасанжаргал гишүүний гаргасан саналыг би дэмжиж байна. Яагаад гэхээр би өөрийнхөө яг тулгамдаж байгаа боловсролын салбарын асуудалтай үүнийг хөндөж хамааруулж яримаар байна.

2017 онд төрийн албан хаагчдын улс төрийн эрхийг хаасан үг, үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаанд оролцох гэх мэт эрх, эрх чөлөөг нь боомилсон, Төрийн албаны хуулиар хориглосон заалт оруулсан байгаа.



Тэгэхээр энэ дээр манай багш нар маш их дургүйцлээ илэрхийлсэн боловч удирдах албан тушаалтнууд нь энэ хуулиа бариад та нар ийм хориотой шүү, хууль зөрчиж байна шүү гэж айлгадаг.

Тэгээд энэ бол улс төрийн намын гишүүнчлэлээс нэгдүгээрт нь түдгэлзүүлж байгаа юм. Төрийн албан хаагчдыг. Тийм ээ.

Хоёрдугаарт нь, улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг хориглож байна гэдэг нь ардчилсан Монгол Улсад байж болшгүй хүний эрхийг боомилсон заалт гэж үзэж байгаа юм.

Тэгээд сонгууль болохоор багш нар шиг хэрэгтэй хүмүүс байхгүй. Бүх сонгуулийн үйл ажиллагаанд багш нарыг тэр чигээр нь хамааруулж татан оролцуулдаг.

Тийм учраас төрийн албан хаагчдын улс төрийн эрхийг боомилсон, хязгаарласан, хүний эрхийг боомилсон хэсгүүдийг ер нь байхгүй болгох хэрэгтэй. Ер нь цэц рүү ч гэсэн хандахад бид буруудах юм байхгүй.

Тэгэхээр энэ яг Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байгаа байхгүй юу. Хүний үг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг боомилсон, Төрийн албаны тухай хуульд Үндсэн хуулийн эсрэг заалт ороод ирсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр би Х.Баасанжаргал гишүүний саналыг дэмжиж байгаа. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Миний зүгээс энэ саналтай холбоотой асуулт байна. Х.Баасанжаргал гишүүнээс. 4 асуудал оруулж ирж байгаа юм байна.

Бид Улсын Их Хурлын хяналт шалгалтын арга хэрэгсэл гээд Хяналт шалгалтын тухай хууль дээр байдаг. Түүний нэг нь мэдээж хууль тогтоомжийн биелэлтийн үр дагавар үнэлгээ хийх, тайлан мэдээлэл сонсох, хяналтын сонсгол хийх, асуулга, асуулт тавих, хамгийн сүүлд Хянан шалгах түр хороо гэж байгаа.

Тэгэхээр энэ 4 асуудлыг харахаар 3 нь үр дагаврын үнэлгээний асуудал байгаа юм.

Үр дагаврын үнэлгээ бол парламентад байдаг Хяналт шалгалтын газар маань үр дагавар нь ямар байна гэдэг цаас дээр ажиллаж үр дагаврын үнэлгээ хийж тайлан гаргах л асуудал шүү дээ. Тийм ээ. Энэ тайланг дараа нь сонсох эсэх нь мэдээж Байнгын хороогоороо явна. Энэ дээр байж байгаа.

Хоёрдугаарт, үр дагавар, судалгаа хийх гэдэг юмыг нэгдүгээрт зөв үү гэдгийг нь Та нэг тодруулаад хэлчих.

---



Хоёрдугаарт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилт байгаа. Бид өмнөх Байнгын хороон дээр ч гэсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн нэг тод жишээн дээр ажилласан.

Тэгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх дээр хяналт шалгалт хийх асуудлыг цаглаварт оруулъя гэж байгаа.

Тэгэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг ямар байдлаар хяналт шалгалтын арга хэрэгслээр оруулахаар нэгдүгээрт Та төсөөлж харж байгаа вэ? Яагаад гэвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай шинэчилсэн найруулга Улсын Их Хуралд ороод ирсэн байгаа. Гэхдээ салбарын сайд татаж аваад хавар дахиад илүү сайжруулаад оруулаад ирье гэсэн байгаа.

Тэгэхээр яг ямар хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуулийн хэрэгжилтийг хяналт шалгалтын ямар арга хэрэгслээр оруулах гээд байна гэдэг дээр Та нэг тодруулаад хариулаад өгөөч.

**Х.Баасанжаргал:** Улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, хөгжих эрх, хууль тогтоомжийн, эрүүгийн процессын гээд асуудлууд, халдашгүй байх эрхийн асуудлууд бүгд судалгааны түвшний үр дагаврын үнэлгээ хийх ийм ажил байгаа.

Тэгээд үнэлгээ хийсний дараагаар бид шаардлагатай гэвэл хууль тогтоомжийн өөрчлөлтийг ярих хэрэгтэй болж таарна. Тэр дундаа зарим салбарууд дээр жишээ нь улс төрийн үзэл бодлыг хязгаарлах зайлшгүй шаардлагууд байдаг.

Тэгэхээр үүний зааг ялгааг бид маш сайн нарийн гаргах ёстой байгаа.

Тэгэхээр энэ зүйлүүд дээр үр дагаврын үнэлгээ илүү судалгааны түвшинд байх ёстой гэж харж байгаа.

Хамгийн сүүлд тэр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, тэр дундаа иргэн болон захиргааны шүүхийн шийдвэрийн биелэлт дээр гэдэг дээр миний төсөөлөл хавар Засгийн газар өргөн барихаас өмнө энэ хяналт шалгалтыг хийгээд, ялангуяа тогтолцооных нь хувьд бид хармаар байгаа юм.

Одоогийн энэ тогтолцоогоороо хууль дээр өөрчлөлт орлоо ч гэсэн үр дүн хэр гарах гэдэг дээр жаахан эргэлзээд байгаа юм.

Иргэн захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг одоогийн байгаа тогтолцоогоороо явуулахад үр дүн гарах уу, үгүй юу. Тийм ээ. Тогтолцооны түвшиндээ, эсвэл энэ нь тусдаа байх ёстой юм уу. Тусдаа шүүх эрх мэдлийнхээ

хүрээнд очих ёстой юу, яах ёстой вэ гээд үүнийг илүү тогтолцоо талаас нь хяналт шалгалтыг хийвэл оновчтой байх болов уу гэж харж байгаа.

Тэгээд Засгийн газар хуулийг өргөн барихад манай хяналт шалгалтын ажил дууссан. Тэгээд тогтолцооны талаасаа бид манай Байнгын хороо энэ дээр шийдэлтэй байх ёстой болов уу гэж харж байгаа.

**О.Номинчимэг:** Ойлголоо. Үр дагаврын үнэлгээний хувьд 5 жил тутамд хийнэ гэсэн байгаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хууль чинь хамгийн сүүлд 2017 онд билүү батлагдсан шиг санагдаж байна.

Тэгэхээр хууль шинэчилж, шинэчилсэн найруулга Хууль зүйн яамнаас хийж байгаатай холбоотой үр дагаврын үнэлгээ хийгдсэн байгаа.

Тэгэхээр ямар арга хэрэгслээр хяналт шалгалтын цаглаварт юу хийнэ гэж оруулах билээ? Түүн дээр л тодорхой байхгүй бол томъёоллын хувьд тэрийг нь нарийн харах уу л гээд байгаа юм.

Х.Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

**Х.Баасанжаргал:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой иргэн, захиргаа гээд энэ саналаа татъя. Хоёр дахь саналаа.

**О.Номинчимэг:** Х.Баасанжаргал гишүүний хоёр дахь санал буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн хяналт шалгалтыг гишүүн өөрөө татлаа.

Х.Баасанжаргал гишүүнээс үр дагаврын үнэлгээ хийх буюу хууль тогтоомжийн судалгаа, үр дагаврын үнэлгээг Хууль зүйн хүрээлэн болон хяналт шалгалтын асуудал эрхэлсэн байгууллагуудаар хийлгэх ийм л 3 санал орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Зөв үү. Тийм ээ.

Нишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлдье. Нийт гурван санал. Тус тусад нь санал хураалгана.

Нэгдүгээр санал. Улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах үр дагавар бүхий хууль тогтоомжийн үр дагаврын үнэлгээ хийх асуудлыг Хяналт шалгалтын цаглаварт оруулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

---

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Хууль тогтоомжийн хүрээнд хүний хөгжих эрхийг хязгаарлах үр дагавар үүсгэж болзошгүй зарим хуулиудын үр дагаврын үнэлгээ хийх асуудлыг Хяналт шалгалтын цаглаварт оруулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.Хууль тогтоомжийн давхардлыг арилгах хүрээнд Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалт нь Цагдаагийн албаны тухай, Прокурорын тухай, Авлигын эсрэг хууль болон Сэжигтэн, яллагдагчийг баривчлах тухай хуульд давхардуулан зохицуулсан зарим зохицуулалтад үр дагаврын үнэлгээ хийх асуудлыг хянан шалгалтын цаглаварт оруулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Х.Баасанжаргал гишүүний саналуудыг хэлэлцэж дууслаа.

Гуравдугаарт, Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамцаас нэг санал ирүүлсэн байна.

Г.Лувсанжамц гишүүн горимын санал гаргах гэж байгаа байх.  
Г.Лувсанжамц гишүүний микрофоныг.

**Г.Лувсанжамц:** Гишүүдийнхээ өдрийн мэндийг хүргэе.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилт дээр 2023 онд ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байсан юм билээ.

Тэгээд тодорхой хэмжээнд ажлын ахиц байгаа учраас тухайн мэдээллийг авсны үндсэн дээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийх эсэхийгээ шийд гаргая гэж бодож байна.

Тэгээд энэ саналаа татаж байна.

**О.Номинчимэг:** Г.Лувсанжамц гишүүн өөрийн гаргасан саналаа татлаа. Энэ саналыг татсанд тооцъё. /алх цохив/

Дөрөвдүгээрт, Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуунаас нийт 4 санал ирсэн үү. Тийм ээ. 4 санал ирсэн байна.

---

Энэ 4 саналыг тус бүрээр нь О.Саранчулуун гишүүн ямар санал юм, яагаад гаргаж байгаа юм, ямар хэлбэрээр хяналт шалгалт хийх юм, иргэд олон нийтээс энэ дээр гарч байгаа өргөдөл гомдлууд, бодит өргөдөл гомдлууд байгаа эсэх тал дээр үндэслэлээ тайлбарлана уу гэж О.Саранчулуун гишүүний микрофоныг өгье.

### **О.Саранчулуун: Сайн байцгаана уу?**

Миний хувьд хамгийн эхний санал нь Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн үйл ажиллагаан дээр хяналт шалгалт хийх санал өгсөн байгаа.

Илүү тодруулаад орлого, зардал, зорилго, үр дүн хэлэлцэх маягаар баймаар юм байна гэж үзлээ. Яагаад гэхээр Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн эрхлэх асуудал дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд явдаг.

Тэгээд энэ дээр маш олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажилд орох болон ажил хайх. Тэр хоёрын хоорондын зуучлалын үйл ажиллагаа болон яг энэ сангийн үйл ажиллагааны хүртээмжийн асуудал олон удаа иргэдээс санал хүсэлт давтагдаж байгаа учраас энэ сангийн үйл ажиллагааг илүү нээлттэй, ил тод, тэгээд дээрээс нь хүртээмжтэй болгох зорилгоор энэ дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Тийм учраас би энэ саналын томъёоллыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020-2025 он буюу сүүлийн 5 жилээр орлого, зардал, зорилго, үр дүнг үнэлэх чиглэлээр хяналт шалгалт хийе гэсэн саналыг оруулж байгаа юм. Тийм.

Тэгээд бид өмнө нь асууж л байсан. Тийм ээ. Тодорхой хэмжээний мөнгө энэ дээр зарцуулагдаж байгаа. Гэхдээ бодитойгоор ажилд орсон хүмүүсийн тоо, ажилд ороод ажиллаж байгаа жилийн хугацааны дундаж тоо, ажилд оруулах, тэр ажлын байр болон ажилд оруулах процесс нь өөрөө хэр хүртээмжтэй байгаа гэдэг нь үнэхээр сайжруулах хэрэгтэй байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид гаргаж ирж үзэж байж, мэдээлэл авч байж энэ дээр дараагийн удаа ингэх хэрэгтэй гэдэг шийдвэр гаргах хэрэгтэй байгаа. Тэгэхгүй жил болгон төсөв болон тайлан дээр нэг ийм мөнгөн дүнгээр тоо тавьчихаад л яваад байхаар энэ нь дутуу дулимаг болоод байгаа учраас энэ дээр анхаарах хэрэгтэй байгаа юм.

Тэгэхээр та бүхэн дэмжиж өгнө үү.

Дараагийн гурван санал нь Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хүрээнд хамрагддаг асуудлууд байгаа.

---

Нэг дэх нь, төв, суурин газар, аймаг, нийслэлийн ундны усны хэрэглээ, хөрсний бохирдол, түүнээс шалтгаалсан өвчлөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх хэрэгтэй байгаа.

Яах вэ, бид усны мониторингийн асуудлыг сүүлийн жилүүдэд анхаараад 2023 он хүртэл дата мэдээлэл байдаг боловч хөрсний мониторингийн судалгаа ер нь хийгдэж байгаагүй асуудлууд байна.

Тэгээд яг энэ нь бид нарын ундны усанд нөлөөлж байгаа. Энэ дээр олон хүмүүс ярьж байгаа боловч хууль эрх зүйн хувьд их нарийн тодорхой зохицуулалт сул юм билээ.

Тийм учраас үүнийг мэргэжилтнүүд нийгмийн эрүүл мэндийн болон хөрс, усны мэргэжилтнүүд ажлын хэсэг, баг үүсээд энэ асуудал дээр анхаарч өгөөч ээ гэдэг бодитой саналууд оруулж ирж байгаа учраас эхлээд хэдүүлээ энэ мэдээллийг бөөнөөрөө харцгаая.

Тэгээд дараа нь тэр оруулж ирж байгаа хуулийн төсөл дээр ажиллая гэдэг үндэслэлээр. Энэ хоёрдугаар асуудал байгаа. Ундны усны хэрэглээ.

Гуравдахь асуудал нь, хог хаягдлын тухай, эрүүл ахуйн тухай, хот суурины ус хангамжийн энэ ариутгах татуургын асуудлууд байгаа.

Бид Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын мэргэжлийн хяналт гээд татан буулгаад. Тийм ээ. Ер нь мэргэжлийн хяналтын эрхлэх асуудлын хүрээнд гал тогоо, хоолны газар байлаа гэхэд хоол хийж байгаа процессоо илүү түлхүү чек листээ шалгаад ажиллаж байгаа нь түлхүү байсан бол одоо тэр чинь бүр нолийн асуудал, тэр жорлон, хөрсний асуудал, хог хаягдалтай холбоотой хэсэг нь их сул бүдэг байна гэж мэргэжилтнүүд үзээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр хуулийн хувьд шинэчлэлүүд хийх зорилгоор энэ хяналт шалгалтын саналыг оруулж байгаа.

Дөрөв дэх нь, Хүнс, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль байгаа. Уг нь миний хөндөөд байгаа асуудал болохоор хүүхдийн аманд хоол орох процесс руу илүү анхаармаар байгаа юм. Яагаад гэхээр хэдий бид бид сайн тогоочтой, сайн гал тогоонд, сайн тээвэрлэсэн хүнс. Гаалийн татвар нь ээлтэй ч юм уу, хүнс байлаа гэхэд яг тэр хүүхдэд хүрч байгаа асуудал дээр бид үнэндээ хуулийн томъёолсон зүйл ч алга.

Тэгэхээр үүнийг ярихын тулд энэ асуудлыг оруулж ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ 4 саналыг маань Та бүхэн дэмжиж өгөөрэй... /минут дуусав/

**О.Номинчимэг:** О.Саранчулуун гишүүнд 1 минут өгье.

**О.Саранчулуун:** Тэгээд мөн энэ дээр би энэ 4-өөс гадна нэг саналыг нэмэх хүсэлтэй байгаа. Тэр нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхтэй адилхан Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагаанд мөн хяналт шалгалт хийх саналыг оруулж байгаа.

Яагаад эрүүл мэндийг дэмжих сангийн асуудал ярьж байгаа гэхээр мөн л нөгөө Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулиараа олон нийтэд чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх зарим ажлууд энэ сангийн хөрөнгөөр зарцуулагддаг байхгүй юу.

Тэгэхээр үүнтэй холбоотой ийм 5 санал болж байна гэсэн үг. Та хэд маань дэмжиж өгөөч ээ. Баярлалаа.

**О.Номинчимэг:** О.Саранчулуун гишүүнд баярлалаа.

О.Саранчулуун гишүүний саналтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн нэрсээ өгнө үү.

Ц.Мөнхтуяа гишүүн, Л.Мөнхбаясгалан гишүүнээр тасаллаа.

Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнхтуяа:** Манай Өргөдлийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар маш чухал чухал саналууд орж ирж байгаад талархалтай байна.

Тэгээд О.Саранчулуун гишүүн Г.Лувсанжамц гишүүний оруулж ирсэн энэ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилт. Үүнийг шалгах нь би зөв л гэж харж байна.

Тэгээд О.Саранчулуун гишүүний тавьж байгаа саналын хамгийн нэгдүгээрт чухал санагдаж байгаа миний хувьд хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах. Тийм ээ. Энэ дээр хүүхдийн үдийн хоолны яг тэр хүүхдийн ам руу орж байгаа процесс. Үүнийг хэн ч ярьдаггүй. Зүгээр л хүүхдийн хоолтой боллоо. Хүүхдийн хоолыг тэгж нийлүүлж байна, чанарыг нь сайжруулж байна л гэж ярихаас яг ямар бүтээгдэхүүн яаж ороод, хэрхэн тэр үйл ажиллагаа, процесс сургууль дээр, хөрсөн дээр, нэгж дээр явагдаж байгааг хэн ч ярьдаггүй.

Тэгэхээр үүнийг бид ярих цаг болсон. Энэ дээр хяналт шалгалт хийхийн тулд бид хамгийн нэгдүгээрт барьж авах хүмүүс бол яг тэр хоолыг түгээж байгаа бага ангийн багш. Тийм ээ. Хүүхдийн үдийн хоолыг түгээж байгаа бага ангийн багш, цэцэрлэгийн багш, дотуур байрны багш. Энэ хүмүүстэй бид нүүр тулсан

ярилцлага хийж, тэр хүмүүсийн ямар процесс, үйл ажиллагаа яваад, юу нь болоод, юу нь болохгүй байгааг бодитоор сонсох шаардлага байгаа.

Тэгэхээр О.Саранчулуун гишүүний гаргаж байгаа саналыг би маш их дэмжиж байгаа.

Тэгээд багш нарыг цуглуулж, нүүр тулсан халз уулзалт ярилцлага хийж, тэр хүмүүсийн үгийг сонсох хэрэгцээ шаардлага байгаа шүү гэдгийг нэмэлтээр санал болгож оруулах гэсэн юм. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Лувсанбямбамаагийн Мөнхбаясгалан гишүүн.

**Л.Мөнхбаясгалан:** О.Саранчулуун гишүүний энэ төв суурин газар, аймаг, нийслэлийн ундны усны хэрэглээ, хөрсний бохирдол, түүнээс шалтгаалсан өвчлөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх гээд.

Би яг процедурыг нь мэдэхгүй л байна л даа. Яг яаж хийх юм. Энэ бүгд байгаа байхгүй юу. Бүх шинжилгээ нь гарсан. Одоо жишээ нь Улаанбаатар хотын 18 мянган худаг бүгд хүн ууж болохгүй. Хөдөө орон нутгаар хийсэн судалгаанууд мөн адил. Нэг худагт 38 нүхэн жорлон оногдох жишээний. Хөрсний бохирдол гээд. Ингээд үе үеийн эрдэмтдийн судалгаа хийсэн. Гол нь энэ дээр урьдчилан сэргийлэлт хийхгүй, эс үйлдэхүй л байгаа байхгүй юу.

Тэгэхээр миний бодол нэгэнт ингээд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас ч юм уу, харьяалагдах байгууллагууд нь, эрдэмтэд нь, яамд газрууд нь судалгаагаа хийгээд товхимол товхимол болгоод шинжилгээний хурал хийгээд батлагдсан юман дээр эс үйлдэхүй л байгаа юм. Энэ эс үйлдэхүйтэй л тэмцмээр санагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр таны энэ хяналт шалгалт хийх нь яг аль чиглэл рүү яг алийг нь хийх юм бэ л гэдэг нь надаа байна. Дахиад л эхнээс нь мэдээлэл цуглуулаад ирвэл знэхээр цаг алдаад байгаа.

**О.Номинчимэг:** Чухал асуулт байна. О.Саранчулуун гишүүний микрофоныг өгье.

**О.Саранчулуун:** Маш чухал. Тийм ээ. Яг тийм.

Тэгэхээр Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль батлагдаад 2 жил орчим болж байгаа. Тэр хуулийн хүрээнд бүтэц буюу Үндэсний зөвлөл гэж байгуулагдах юм.

---

Тэгээд энэ нь яг эцсийн байдлаар албажиж ирсэн нь мэдээллийг би аваагүй. Ер нь өмнө нь Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр өнгөрсөн хавар ярьж байсан юм.

Энэ зөвлөлд нь юу орж байгаа вэ гэхлээр таны саяын хэлсэн салбар бүрийн албан хаагчид, салбар бүрийн төлөөллүүд энэ зөвлөлд нь орж Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ийм бүтэцтэй байгаа. Энэ хууль нь.

Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд өөрөөр хэлбэл тэр эс үйлдэхүй гэдгийн цаана хуулиараа үүнийг заасан. Тэгэхдээ тоон мэдээлэлд үнэ гарсан. Одоо аль салбар юугаа хийх юм. Жишээлбэл аж ахуйн нэгж, байгууллага шинээр байгуулагдахдаа жорлонгийн асуудлаа яаж шийдэх юм гэдгийг бид өнөөдөр хуульчилж өгөхгүй л юм бол болохгүй байгаа. Гэтэл хуулийн санаачилга гаргахын тулд салбарынх нь сайд нь ч юм уу, салбарынх нь удирдах зөвлөлийн хүмүүсийн оролцоо маш чухал байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр таны хэлээд байгаа эс үйлдэхүйг үйлдэл болгохтой холбоотой зохицуулалтыг гаргах зорилгоор одоог хүртэл цугласан байгаа мэдээллээ хэдүүлээ аваад, энэ дээр үндэслээд тэгвэл ямар чиглэлтэй ямар акшн буюу үйлдлүүд хийх төлөвлөгөөг нь гаргуулах зорилгоор би үүнийг яриад байгаа гэсэн үг.

Тэгэхгүй яг үнэн. Орхигдоод байгаа. Нийслэлд 600 мянган нүхэн жорлон байна гэж ярьсаар л байгаа. Шинээр аж ахуйн нэгж, байгууллага ер нь нийслэл болон төв суурин газарт бий болж л байгаа бол тэнд бид хөрсний бохирдлоос сэргийлэх тэр журам дүрмийг нь зөвшөөрөлд нь оруулдаг ч юм уу, энэ дээр нэг тийм процессыг нь илүү зааж чиглүүлж ингэж хянаж өгөхгүй бол бид энэ нүхэн жорлонгоосоо салахгүй.

Тэгээд хөрсний бохирдолтойгоо хэвээрээ, ус нь бохир хэвээрээ байх гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр ийм зорилго агуулгаар л энэ хяналт шалгалт гэж санал оруулсан юм байгаа юм.

Тэгэхээр энэ дээр хэдүүлээ хамтарч ажиллаад шийдэл гаргалгаагаа илүү нүдэнд харагдаж, гарт баригдахуйц болох боломжтой гэж үзээд байна л даа. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Миний зүгээс О.Саранчулуун гишүүний саналтай холбоотой асуултууд байна.

---



Нэгдүгээр асуулт бол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан. Өөрөө шинээр сая дахиад Эрүүл мэндийн дэмжих сангийн юу гэх шиг боллоо. Тийм ээ.

Тэгээд сая Г.Лувсанжамц гишүүн хэлсэн. Өмнө нь ажиллаж байсан ажлын хэсгийн бас нэг тайлан дүгнэлт байгаа юм байна. Хассуурийн Ганхуяг гишүүн ажиллаж байсан.

Тэгэхээр үүнийгээ хараад нэгмөсөн бүх сангууд дээр л хийсэн бололтой юм. Нэгдүгээрт. 12 удаа хуралдаад хийсэн ажил байгаа юм байна. Тэрийг та харж байгаад санал оруулах уу? Яагаад гэвэл нэгдүгээрт тэнд хийгдсэн ажлыг давхар давхар хийгээд байхаар хүч тарамдана.

Хоёрдугаарт, та хянан шалгалтын ажлыг цаглаварт оруулъя гэж байгаа чинь яг юу хийхээр юм бэ?

- Үр дагаврын үнэлгээ хийх гээд байгаа юм уу.
- Ажлын хэсэг байгуулах гээд байгаа юм уу.
- Тайлан мэдээлэл сонсох гээд байгаа юм уу.

Тэр хэлбэрийг нь оруулж өгөхгүй бол ерөнхий байдлаар бид мэдээж Төрийн байгуулалтын байнгын хороо руу явуулахгүй. Ямар хэлбэрээр бид хяналт шалгалт хийх гээд байгаа юм бэ гэдгээ оруулах ёстой юм.

Нэгдүгээр асуулт дээр сан дээр байна.

Хоёрдугаар асуулт болохоор энэ хөрсний бохирдол, түүнээс урьдчилан сэргийлэх ажил. Дэмжиж байна. Хог хаягдал, эрүүл ахуй, хот суурин, усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын хуулийн асуудал. Дэмжиж байна. Ялангуяа хүүхдийн хоолны асуудал маань Ц.Мөнхтуяа гишүүн хэллээ. Олон эмэгтэй гишүүд хүүхдийн хоолны шим тэжээлийн асуудал, аюулгүй байдлын асуудал дээр анхаарч байгаа. Тал талаас нь л цөмөөрөө ярьж байна

Тэгэхээр яг энэ дээр хяналт шалгалт хийнэ гэдэг маань ямар арга барилаар. Нөгөө арга байгаа шүү дээ. Хуульд заасан. Энэ дээр ямар аргаар, юу хийе гэж бодоод байна гэдгээ нэг тодруулж хэлээд. Нөгөө давхардсан, давхардаагүй юмнуудаа яахгүй бол гэж бодоод байна. Түүнд та нэг хариулт хэлээч.

**О.Саранчулуун:** Баярлалаа. Засгийн газрын тусгай сан гэдэг зүйл иргэдэд нэгдүгээрт өөрөө их ойлгомжтой биш байсан нь Боловсролын зээлийн сан, ЖДҮ хоёроос болж хүмүүс мэддэг болсон. Тийм ээ. Гэтэл хүмүүсийн мэддэггүй, тэгэхдээ тодорхой хэмжээний мөнгө төвлөрдөг сангууд байна. Тэгэхдээ тэр нь бас л ил тод биш, хүртээмжтэй биш асуудлууд байсаар л байдаг.

Миний хувьд илүү үр дүнг үнэлэх ийм хяналт шалгалтыг хиймээр байгаа байхгүй юу. Тийм.

Г.Лувсанжамц гишүүний ажлын хэсэгт миний бие бас тэр ажлын хэсэгт байсан. Тэгэхдээ тэнд ирж байгаа мэдээллүүд дансны хөлийн дүн гэж орж ирдэг шиг илүү багцалсан мэдээллүүд орж ирээд байгаа байдал нь дотроо хаягдаад байгаа, орхигдоод байгаа, хангагдахгүй байгаа зарим хүн амын бүлэг, хүрч үйлчлэх ёстой хүн амын бүлэг, хүрэх хүрэхгүй асуудал ч байдаг юм уу хэт өнгөц мэдээллүүд том зургаараа орж ирсэн байдаг. Ер нь хараад байхад.

Гэтэл бид Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын үйл ажиллагааны бүр доторх нарийн юм руу нь ороход их төвөгтэй.

Тэгэхээр хяналт шалгалтын үр дүнг үнэлэх, хяналт шалгалтын арга нь илүү задалж үзээд үнэхээр Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хуульд хүн амыг өвчнөөс сэргийлэх, дэмжих үйл ажиллагаанд энэ сангаас жишээлбэл яг ямар мөнгө зарцуулаад үнэхээр эрүүл мэндийн мэдлэг боловсрол яаж дээшилсэн гэдгийг үр дүнг л үнэлмээр байгаа байхгүй юу.

Ер нь нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн тухай асуудлыг ярихаар хүмүүсийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тэр мэдлэгтэй болгох, боловсролтой болгох асуудлыг эрүүл мэндийг дэмжих сангаар гээд л орхидог байхгүй юу.

Гэтэл нэг сан байгаад байдаг. Хүмүүсийн мэдлэг, хандлага улам дордоод л, халдварт өвчин, халдварт бус өвчин улам нэмэгдээд байгаа учраас үр дүнг үнэлэх чиглэл рүү илүү хармаар байгаа юм.

Одоо байгаа мэдээлэл байвал тэрийгээ аваад, илүү үр дүн дээр ямар үр дүн гарсан юм бэ гэдгийг хармаар байгаа юм.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээр дахиад хэлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал нь нэлээн нарийвчилж илүү хармаар байгаа. Дээрээс нь энэ хоёр сан дээр хоёулан дээр нь тл тод байдал, хүртээмж гэдэг ойлголтыг илүү сайн авахыг хүсэж байгаа.

Хүнсний асуудал дээр болохоор мөн адилхан. Хүүхдийн ам руу хоол идэх холбоотой тэр процедур гэж ярих юм уу. Хүүхдийн хооллох орчинтой холбоотой асуудлыг аль ч хуульд ерөөсөө бид ярихгүй байгаа. Гараа угаах тухай асуудал ярихад 30 хүүхэд дундаа ганцхан кранттай байхад хүүхдүүд гараа угааж угаасаа амжихгүй. Дээрээс нь гар угаах цаг, хоол идэх цаг нь хангалттай биш байгаа. Цэцэрлэг, сургууль дээр.

---

Тэгэхээр хэчнээн бид сайн хоол, хэчнээн сайн тээвэрлэгдсэн хүнс, хэчнээн сайн нөхцөлтэй байвч тэр зан үйл, тэр дадал зуршил, орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байгаа. Энэ нь аль ч хуультай уялдаатай тусгайлан заагдаагүй учраас энэ хоёр хуулийг л авч үзээд байгаа байхгүй юу.

Энэ дээр бид Боловсролын тухай хууль, Багшийн тухай хуулиа нэмж оруулж томъёолох хэрэгтэй байна л даа. Байхгүй байгаа зүйлийг л анхаараач гэдгийг оруулж ирэх зорилготой яваад байгаа гэсэн үг байхгүй юу. Санал маань.

Тэгэхээр ойлгогдож байна уу?

**О.Номинчимэг:** О.Саранчулуун гишүүн ээ, би асуудлын ямар чухал байгаа, тулгамдаж байгаа гэдгийг бүгдээрээ ойлгож байгаа. Бүгдээрээ санал дэмжиж байгаа.

Гэхдээ бид Улсын Их Хурлын гишүүд чинь хуулийнхаа дагуу үйл ажиллагаагаа явуулах ёстой.

Тэгээд хуульд энд хяналт шалгалт хийх хэлбэрүүдийг заасан байгаа. Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль дээр.

Би танаас асуугаад байгаа нь ийм мэдээлэл авмаар байна гэж байгаа. Гэхдээ тэр чинь мэдээлэл чинь нэгдүгээрт тэр нэг ажлын хэсэг гарсан байгаа юм байна. Тэрийгээ харсан уу? Тэнд үнэхээр байхгүй байгаа юм уу?

- Байхгүй байгаа бол үр дагаврын үнэлгээ хийх гээд байгаа юм уу?
- Яг юу хийх гээд байгаа юм бэ?
- Бусад дээрээ ажлын хэсэг байгуулах гээд байгаа юм уу?
- Эсвэл тайлан мэдээлэл сонсож хэлэлцэх гээд байгаа юм уу?

-гэдэг хэлбэрээ заагаад өгөөч ээ. Бид санал хураана. Томъёоллоороо санал хураана. Тэрийгээ Төрийн байгуулалтын байнгын хороонд оруулах байхгүй юу. Төрийн байгуулалтын байнгын хороо чинь үүнийгээ шалгаад хуульд нийцэж байна уу, үгүй юу гэдэг юмыг тэндээ санал хураана шүү дээ.

Тэгэхээр бид эхнээсээ оруулахдаа ийм үндэслэлээр оруулж байгаа, ийм хэлбэрээр юм гэдгийг л оруулах гээд байгаа юм л даа.

О.Саранчулуун гишүүний микрофон.

**О.Саранчулуун:** Хоёр тусгай сангийнхаа хувьд үр дагаврын үнэлгээн дээр ажиллах чиглэлээр саналын томъёоллоо оруулъя.

Үлдсэн гурван санал дээр тайлан илтгэл хэлэлцэх буюу энэ процесс яаж явж байна гэдэг дээр тайлан илтгэлийг хэлэлцвэл илүү оновчтой юм уу гэж бодож байна. Байнгын хороон дээр. Тийм ээ. Болж байна уу?

**О.Номинчимэг:** Ийм байгаа юм. Тийм. Би Байнгын хорооныхоо ажлын албанд хэлээд байж байна.

Гишүүд маань мэдээж санал санаачилга, асуудлуудаа асуудал нь энэ байна. Ингэмээр байна гэдгийг оруулж ирж болно. Тэр нээлттэй. Тэгэхийн тулд бид өнөөдөр энэ хурлыг хийж байгаа. Гэхдээ давхардахгүй байх, хуулийн дагуух хэлбэр аргаар нь явах л гэдэг асуудал дээр Байнгын хорооны гишүүд хэрвээ гишүүдээс санал ирсний дараа яг энэ санал өгсөн гишүүд өөрсдөө ажлын албатай, ажлын албаны ахлах зөвлөхтэй ямар хэлбэрээр юу байх вэ гэдгээ нарийвчилж ярьж тохирох ёстой. Тэгж байж оруулах ёстой байгаа юм.

Тэгэхгүй бол одоо жишээ нь үр дагаврын үнэлгээ хийнэ гэж байгаа.

Тэгэхээр энэ сангууд дээр чинь тэгвэл сүүлийн 5 жилд үр дагаврын үнэлгээ хийсэн байх юм бол давхардаж байгаа байхгүй юу. Үнэхээр хийгдсэн юм уу, хийгдээгүй юм уу, чеклээд хийгдээгүй байна, ийм орон зай байгаа учраас гэдэг үндэслэлтэй байх ёстой байтал одоо би жишээ нь үр дагаврын үнэлгээ хийгдсэн эсэхийг нь мэдэхгүй. Г.Лувсанжамцямц гишүүн маань ч гэсэн өмнө нь ажлын хэсэг байсан юм байна, ингэж байсан юм байна, тэр харж байгаад больё гээд байна шүү дээ. Тийм ээ. Нэг ийм давхардсан нэг тийм шалгаагүй юм руу л явах гээд байна л даа.

Тэгэхээр яах вэ? Нөгөөдүүлээ ажлын хэсэг байгуулъя. Биш ээ. Юу, тайлан мэдээлэл сонсьё. Тайлан мэдээлэл сонсьё гэдэг дээр байгаа. Тийм ээ? Ойлголоо. Энэ гурав дээр.

Юутай ч санал хураая. Тэгэх үү? Санал хураалтдаа бэлдье.

Отгоны Саранчулуун гишүүний гаргасан 5 саналаар санал хураалт явуулах нь.

Нэгдүгээрт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны 2020-2025 оны орлого, зарлага, үр дүнгийн үнэлгээнд. Үр дүнгийн үнэлгээ ч гэж байхгүй л дээ. Энэ чинь Хөдөлмөр эрхлэх сангийн тухай хуулийн, тэгээд тусгайлсан заалтынх нь буюу хэсгийнх нь л үр дагаврын үнэлгээ болох ёстой биз дээ.

Томьёолж орж ирэхгүй болохоор чинь ингээд байна шүү дээ. Сайтар ярилцаж уг нь орж ирэх ёстой.

---

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн үр дагаврын үнэлгээ хийх ажлыг Хяналт шалгалтын цаглаварт оруулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 50 хувь буюу санал дэмжигдсэнгүй.

Хоёр.Төв суурин газар, аймаг, нийслэлийн ундны усны хэрэглээ, хөрсний бохирдол, түүнээс шалтгаалсан өвчлөл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар тайлан мэдээлэл сонсох, хяналт шалгалт хийх ажлыг цаглаварт оруулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.Хог хаягдлын тухай, Эрүүл ахуйн тухай, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тайлан, мэдээлэл сонсох, хяналт шалгалт хийх ажлыг цаглаварт оруулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Дөрөв.Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, Хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж байгаа үйл ажиллагааны талаар мэдээлэл сонсох, тайлан илтгэл хэлэлцэх.

Энэ дээр үр дагаврын үнэлгээ хийлгэх юм уу? Хийсэн юм байгаа юм уу? Тайлан уу?

Тайлан мэдээлэл сонсох, хяналт шалгалт хийх ажлыг цаглаварт оруулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

57.1 хувиар саналаар дэмжигдлээ.

Тав.Эрүүл мэндийг дэмжих сантай холбоотой хуулийн хэрэгжилтийн талаар үр дагаврын үнэлгээ хийх хяналт шалгалтын ажлыг цаглаварт оруулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

50 хувь буюу санал дэмжигдсэнгүй.

Ингээд Отгоны Саранчулуун гишүүний гаргасан 5 саналаар санал хурааж дууслаа.

Тав дахь буюу Жанчивын Галбадрах гишүүний гаргасан саналыг цөмөөрөө хэлэлцье.

---

Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрахаас хоёр асуудлаар хянан шалгалт хийх, цаглаварт тусгуулах саналыг гаргасан байна.

Тэгэхээр уг саналаа тайлбарлаж, ямар үндэслэлтэй, иргэд олон нийтээс гарч байгаа өргөдөл, санал ямархуу санал гэдгийг гишүүн тайлбарлаж өгнө үү?

Жанчивын Галбадрах гишүүний микрофоныг өгье.

**Ж.Галбадрах:** Байнгын хорооны дарга, гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Би ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг дээр их яригдаж байгаа хамгийн том асуудал болж байгаа зүйлийн талаар ярья.

Нэгдүгээр асуудал нь, ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хууль гэж 2019 онд баталсан хууль байдаг. Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх бага, дунд боловсролын хуульд энэ талаар тусгасан байдаг.

Тэгэхээр өнөөдөр сургуулиуд маань өөрөө хүчин чадал нь өөр өөр. Сумын сургууль, аймгийн сургууль, хотод, нийслэлд гэхэд гэр хорооллын сургууль, хотын төвийн сургууль гээд хүчин чадлууд нь өөр өөр ялгаатай байдаг. Үүнээсээ хамаараад сургуулийнх нь удирдлага, менежмент, зохион байгуулалтын асуудал ч гэсэн даац хэтэрснээс болоод, эсвэл сурагчийн тоо маш цөөнөөс хамаараад гээд өөр өөр ялгаатай байгаа.

Тэгэхээр бид ялгаатай байдлыг нь харгалзаж үзээд хоол үйлдвэрлэлтэй холбоотой үйлчилгээ, ялангуяа хоол хүргэлт, түгээлт, амт чанар, илчлэг байдал, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа байдлыг зайлшгүй үзэх шаардлагатай байна.

Тэгээд сургууль дээгүүр тойроод үзээд явахад –

- ялгаатай үйлчилгээнүүд явагддаг,
- ялгаатай хоол үйлдвэрлэл явагддаг,
- ялгаатай амт чанар явагддаг зүйлүүд байж байгаа.

Тэгэхээр энд бид жишиг тогтоогоод нэг тийм стандарт тал руу нэлээн явах хяналт шалгалт зайлшгүй хэрэгцээтэй байна гэж үзсэн учраас нэгдүгээр саналыг гаргаж байгаа юм.

Тэгээд үүнийг жишээ татаад яриад байвал маш л олон зүйлүүд байдаг. 8 хувь нь гэдэг юм уу, хийчхээд аяга тараагаад, дээр будаатай хуурга өгөөд явдаг байна.

---

Одоо бид –

- “үдийн цай”-г,
- “үдийн хоол” болгоод,
- “халуун хоол” болгох –

-гэдэг түвшин рүүгээ зорьж ирээд байгаа боловч “үдийн цай” гэхээр нэг жүүс, ундаа, нарийн боов тарааж өгөх хэмжээнд байж байгаа ч газрууд байгаа.

Тэгэхээр үүнийг бид зайлшгүй жигдлээд, тэгээд энэ дээр үр дагаврынх нь үнэлгээ.

Хүүхдүүд үнэхээр үдийн хоолоо идэх гэж л сургууль руу ирдэг гэсэн зүйлүүд байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг цогцоор нь хянаж шалгах шаардлага байна гэж үзсэн учраас энэ саналыг гаргасан.

Хоёр дахь нь, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль гэж 2018 онд гарсан.

Тэгээд Засгийн газраас ч гэсэн Боловсролын яамнаас “Багшийн гурван тулгуурт бодлого” гээд цогц арга хэмжээний тухай ч зүйлүүд гарч ирсэн.

- Багшийн хомсдол бодитоор нүүрлэсэн.

- Багшаа чанаржуулах,
- тоогоор нь хангах,
- тоон болон чанарын дутагдлыг алга болгох зайлшгүй шаардлага байгаа.

- Багшаа ажлын байран дээр нь хөгжүүлэх шаардлага байна.
- Ажлын байрны ачаалал, зураглал.

Сүүлийн жилүүдэд багш нар ажлаасаа хурдтай гардаг болсон.

Багш ажлаас гарах хурдац нэмэгдсэн шалтгааныг бид судалсан.

Үнэхээр тэр хөгжил гэдэг зүйл нь явагдаад, “багшийн карьер” гэдэг зүйлийг бид анхаарах ёстой. Нэг л багш болсон бол насаараа тэр сургуульдаа, тэр газраа багш болоод үлдээд байгаа бол үүнийг бид цогц байдлаар авч үзэх шаардлагатай.

---

Энэ үүднээс бид саяын хэлсэнчлэн ялгаатай байдал, сумын сургууль, аймгийн сургууль, хотын зах, гэр хороолол, хотын төвийн ачаалал ихтэй сургуулиуд дээр тохирсон багш сургалтын хөтөлбөр ямар байх вэ.

Өнөөдөр цогц арга хэмжээ гэж яригдаад байгаа зүйлүүд ер нь яг бодитой суугаад багш нар маань хөгжиж байна уу гэдгийг шалгах зайлшгүй хэрэгцээ шаардлага байна гэж үзсэн учраас энэ саналыг гаргасан.

**О.Номинчимэг:** Ж.Галбадрах гишүүнд баярлалаа.

Ж.Галбадрах гишүүний саналтай холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүн нэрсээ өгнө үү? Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүнээр тасаллаа. Ц.Мөнхтуяа гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнхтуяа:** Сургууль, цэцэрлэгийн үдийн хоолон дээр асуудлууд маш их байгаа. Бид нарт зөндөө их кейсүүд ирдэг. Багш нараас.

Тийм ерөнхий маягтай юм бид яримааргүй байна. Яг бодитоор нь. Хоол өгөх хэрэг байна уу, байхгүй юу гэдгээс бараг эхэлнэ.

Зарим сургуулиуд “үдийн хоол” идэхгүй. Түрүүн ярилаа шүү дээ. 8 хувинтай хоол нь талаас дээгүүр буцдаг. Тийм ээ. Ийм сургуулиудад “үдийн хоол” өгөх хэрэг байна уу? Үдийн хоолтой холбоотойгоор хэсэг бүлэг хүмүүсийн кармааг түнтийлгэх зарчимгүй юм ч бид нарт ирдэг. Мэдээллүүд. Хүүхдийн үдийн хоолонд хэдхэн компаниуд монополдож тендер зарлаж аваад тэгээд юу ч хамаагүй шахаад сууж байдаг. Үнээ юу хэд ч хамаагүй хэлээд сууж байдаг энэ байдлыг бид нэлээн сайн нарийн шалгах хэрэгтэй.

Тэгээд хүүхдийн ам руу яг чанартай хоол орж байна уу, үгүй юу гэдэг чинь бас асуудал байна.

Тийм учраас зүгээр ерөнхийлсөн биш. Бид бас сургууль, цэцэрлэгүүдээр явах хэрэгтэй. Багш нартай уулзах хэрэгтэй. Орчин дээрээ ямар байгаа юм. Тийм ээ. Гэх мэтчилэн маш олон асуудлууд шийдлээ хүлээгээд байж байгаа шүү. Бид зүгээр нэг өнгөц төдий хүнд таалагдах ч юм уу. Тийм ээ. Тэгье ингэе гээд яг нэг тийм тодорхойгүй юм яриад байна, зарим асуудал дээр.

Тэгэхээр үдийн хоолон дээр яг ямар шалгуур тавиад юуг шалгах юм? айн үдийн хоолон дээр яг юуг нь шалгах гээд байгаа юм гэдгийг нь ямар ч тодорхойгүй ингээд яриад сууж байна.

Тэр багшийн хөгжил карьер. Өнөөдөр багш нарынхаа нийгмийн асуудлыг шийдэж чадаагүй бид хөгжил карьер ярих ямар ч боломжгүй. Багшийн цалин хөлс



өнөөдөр сая төгрөг бараг хүрэхтэй үгүйтэй 60-аас 70 хувь нь ийм цалин авч байгаа шүү дээ.

Боловсролын салбарын багш, ажилчдыг судалгаагаар үзэхэд 60-аас 70 хувь нь дандаа залуу багш нар байгаа. Тэр багш нар чинь өнөөдөр 900 мянган төгрөг ч хүрэхгүй мөнгө гар дээрээ аваад сууж байгаа шүү дээ. Тийм хүмүүс ямар хөгжил карьер ярих юм. Бид эхлээд энэ багш нарынхаа нийгмийн асуудал, цалин хөлс. Тийм ээ. Ингэж байж багшийн ажил тогтвортой, хөгжилтэй: чадвартай хүмүүс орж ирнэ. Түүнээс энэ хөтөлбөр төлөвлөгөөндөө ч байгаа юм биш, карьертаа ч байгаа юм биш. Ер нь хамгийн чухал сэдэв багш нарынхаа нийгмийн асуудлыг зоригтой ярихгүйгээр бид өнөөдөр тулга тойрсон өнөө маргаашийн аргацаасан юм яримааргүй байна. Яягүй зоригтой том шийдэл, том асуудал руугаа яримаар байна гэдгийг би удаа дараа хэлж байгаа. Ер нь цаашдаа ч хэлнэ. Ийм л байна.

**О.Номинчимэг:** Асуулт асуусан. Тийм ээ. Үг хэлж байгаа юм уу? Тодорхойгүй байна. Тэгвэл яг юуг нь шалгах гээд байгаа юм гэдэг дээр Ж.Галбадрах санал гаргасан гишүүн хэлье.

Түүнээс өмнө С.Замира гишүүн, Г.Лувсанжамц гишүүн асуулт асуухаар нэр өгснийг оруулаарай. Ж.Галбадрах гишүүний микрофон.

**Ж.Галбадрах:** Өнөөдөр асуудлаа гаргаж ирж тавьж байгаа.

Бид шалгаад үзээд явъя гэвэл бүр маш нарийн зүйлүүд маш их бий. Харин тийм. Тэрийг чинь бид удирдамж дээрээ гаргаад өнөөдөр явах юм биш үү. Өнөөдрийн энэ 3 минутын дотор яагаад энэ асуудлынх нь цаад үндэс шалтгаан нь байгаа вэ гэдгээ бид гаргаж ирж байна.

Зүгээр хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой. Жишээлбэл, амт чанар. Сургууль болгоны захирал нь өөрөө сонгон шалгаруулалтаа хийгээд ямар компанийг хаанаас яаж авах вэ? Маш сайн сонгон шалгаруулалт хийгээд маш сайн үр дүнтэй халуун илчлэг хоол өгөөд байгаа сургууль яг адилхан нөхцөлд байгаа мөртлөө байгаа. Гэтэл тэр нь шал өөрөөр маш дутмаг өгч байгаа сургуулиуд ч байж байна.

Тэгэхээр бүгдээрээ амт чанар, үйлдвэрлэл, ямар компанитай, хэдэн төгрөгийн үнэтэйгээр, ямар хоолыг ямар менютэйгээр яаж өгч байгаа юм гэдэг талаас нь бид гаргаж ярих ёстой. Энэ дээр сургуулиуд ялгараад гараад ирнэ. Үүнийг би өөрөө орон даяар сургуулиудыг тойрч явж үзэж танилцаж байсан хүний хувьд энэ зүйлийг сайн мэднэ.

Нөгөө талаас багшийн үндсэн цалин, нийгмийн халамжийн асуудлуудыг бид яриад 2026 онд “Боловсролыг дэмжих жил” болж байна.

---

Тэгээд цалин хөлс нэмэх асуудлуудаа бид тодорхой хэмжээнд шийдээд явж байгаа. Өнөөдөр бид багшаа хөгжүүлэх гэдэг асуудлуудыг ахиад л том циклээр нь яриад л байвал бид ёстой ерөнхий ярьсаар байгаад таарч байна.

Тэгвэл өнөөдөр багшийн хөгжлийг дэмжих тухай хууль гээд гарч ирээд энэ маань 2018 оноос яваад “Багшийн гурван тулгуур цогц бодлого” гэж гарч ирээд хэрэгжээд явж байгаа зүйл дээр бид яг багшийг хөгжүүлэх асуудал.

Өнөөдөр үнэхээр багш ахиад л сая төгрөгөөс доош цалинтай байгаа гэдэг энэ юмыгаа яриад суух биш бид өнөөдөр цалингаа тодорхой хэмжээнд шийдсэн.

2026, 2027 онд яаж шийдэх вэ гэдэг зүйл тодорхой гараад ирсэн байгаа учраас бид –

- хөгжлийнх нь асуудал,
- ажлын байрных нь асуудал,
- карьерынх нь асуудал.

Энэ бүгдийг бид ярихгүй зөвхөн цалин гэдэг асуудлуудыг тойроод яриад байхгүй.

Тэгэхээр энэ чиглэлээр нь энэ асуудлуудыг судлаад явъя гэдэг үүднээс оруулж ирсэн юм байгаа шүү.

**О.Номинчимэг:** Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн тодруулъя.

**Ц.Мөнхтуяа:** Цалин яаж нэмэгдэх юм, хэдэн төгрөг, хэдэн хувиар нэмэгдэж байгаа нь ямар ч тодорхой биш байгаа шүү дээ. Яг одоо. Би лав сонсоогүй.

Сүүлийн 30 жилд баахан л хөтөлбөр, төлөвлөгөө ярилаа. Баахан л Кембриж ярилаа, баахан л Японы сургалт, “Зөв монгол хүүхэд” ярилаа. Өнөөдөр үр дүн хаана байгаа юм. Үр дүнгүй байгаа биз дээ.

Тэгээд бид үр дүнгүй юмаа засаад сайжруулаад. Ер нь багш нарын хэлж байгаа хамгийн гол чухал санаа бид хөгжих юман дээрээ хэнээр ч заалгахгүй. Хөгжөөд явна. Хамгийн чухал юм бид өнөөдөр цалин багатай учраас ар гэртээ зарцуулах ямар ч төсөв мөнгөгүй, өрнөөс өрний хооронд үр хүүхдээ хаяад хүний хүүхдийн төлөө явж байна. Төр засаг нь энэ дээр анхаарахгүй юм уу л гэдэг асуудлыг ярьж байгаа шүү дээ.

Өчнөөн л хөтөлбөр, өчнөөн л олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр гээд л өчнөөн хэдэн мянган доллар бид зарцуулаад л байгаа шүү дээ.

---

Тэгээд хөгжсөн юм өнөөдөр хаана байна аа? Үр дүн байхгүй байна шүү дээ.

Тэгээд үр дүн... /минут дуусав/

**О.Номинчимэг:** Ц.Мөнхтуяа гишүүнд нэмэлт 1 минут.

**Ц.Мөнхтуяа:** Тэгээд үр дүнгүй юмаа бид ингээд л тулга тойроод яримааргүй байна. Үр дүн болохуйц, тодорхой хэмжигдэхүйц баймаар байна. Ер нь манай багш нарын хэлж байгаа хамгийн гол санаа баахан хөтөлбөр, төлөвлөгөө, баахан сургалт, үе үеийн явуулдаг хэдэн шахааны хэдэн хүмүүсийн сургалтыг интернэт цахим сургалт гэж явуулаад, тэд нар нь мөнгийг нь карманлаад, бид нарт ирж байгаа юм алга. Хичээлийн хажуугаар тэр сургалтаа ав, энэ сургалтаа ав гээд дарамттай аягүй хэцүү байна аа, Ц.Мөнхтуяа багш аа гээд надад өдөр бүр багш нарын гомдол ирж байгаа.

Тэгээд үүнийгээ яах юм хэдүүлээ. Зүгээр өнгөц төдий элсэн юм яримааргүй байна. Одоо энэ болохгүй байгаа юмнуудыг нь болиулаад, болох юмыг нь хөдөлгөмөөр байна шүү дээ.

Тэгээд цалин ярингуут дандаа цалин ярихгүй гэнэ. Тэгээд цалингүй ажил хэн хийх юм. Сая төгрөг аваад багшийн ажил хийх залуучууд өнөөдөр байхгүй болоод багш мэргэжлээр төгссөн мөртлөө ажлын байран дээрээ байхгүй байна шүү дээ. Багш хомсдоогүй байх.

**О.Номинчимэг:** Бид чинь өнөөдөр хяналт шалгалтын цаглаварт асуудлуудаа яаж оруулах вэ гэдэг дээр байгаа шүү дээ. Тийм ээ. Хоол үйлдвэрлэлийн асуудал дээр бүгд маш их анхаарч байгаа. Ж.Галбадрах гишүүн хариулах уу? Ж.Галбадрах гишүүний микрофоныг.

**Ж.Галбадрах:** Тийм. Бид өнөөдөр Өргөдлийн байнгын хороон дээрээ яг энэ хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал, багшийн хөгжлийг дэмжих асуудлаа л ярьж байна.

Тийм. Энэ хоёроо л ярьж байна.

Тэгэхээр бид өнөөдөр багш маань хөгжүүлэх асуудлаа бид зэрэг ярихгүйгээр үр дүнгүй байсан юм гээд. Өнөөдөр үр дүнтэй сайн талыг нь ярих хэрэгтэй. Би лав энэ гурван тулгуур цогц хөтөлбөр хөгжөөд, сургалтдаа суугаад, идэвхтэй маш сайн хөгжсөн гэдэг багшийн яриаг олныг сонсож байсан. Мэдээж үр дүнгүй байгаа гэдгийг сонсож байсан.

Тэгээд хэдэн хувь нь сайн байгаа юм. Бид эерэг сайн зүйлээ ярьж давтаж явахгүй дандаа л улныхаа юм шиг, дандаа муу юм шиг байдлаар асуудалд хандаад явах юм бол. Багш нарынхаа үнэлэмжийг дээшлүүлье гэвэл бид сайн

---

талаа ярьж явах ёстой. Багш хөгжиж байгаа гэдэг дээр би санал нэгтэй байгаа. Тэгэхдээ тодорхой хувьд нь мэдээж хүрэлцэхгүй байгаа зүйл байгаа. Тэгэхдээ бүгдээрээ сайныг нь яриад явах ёстой.

**О.Номинчимэг:** Дууссан даа. Ц.Мөнхтуяа эгч.

Г.Лувсанжамц гишүүн асуулт асууж, үг хэлье.

**Г.Лувсанжамц:** Өдрийн мэнд хүргэе.

Ж.Галбадрах гишүүний гаргаж байгаа хяналт шалгалт хийх товд оруулах.

- ▷ **Нэгдүгээрт нь,** ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай.
- ▷ **Хоёрдугаарт нь,** Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хянана гэж байгаа.

Энэ саналыг дэмжиж байна.

Ц.Мөнхтуяа гишүүн маань сая боловсролын салбарт тулгамдаад байгаа асуудлуудыг хэллээ. Хоол хүнс ямар байгааг ярьж байна. Тийм ээ.

- Сая хэдүүлээ –
  - төсөв батлахдаа “Боловсролыг дэмжих жил” болгож зарласан.
  - Багш нарын цалинг гурван үе шаттайгаар 76 хувь нэмье гэж ярьсан.

Энэ дээр таны оролцоо, Ж.Галбадрах гишүүний оролцоо, С.Эрдэнэбат гишүүний оролцоо бүгдээрээ л дэмжиж баталсан.

Хяналт шалгалт хийх гээд байгаа гол зорилго нь хэдүүлээ шийдэл ярилцъя гэж байгаа. Асуудал байгааг бүгдээрээ мэдэж байна. Хэдүүлээ хамтраад хаана нь асуудал байгаа юм тэр асуудлыгаа шийдье гэж байгаа юм. Жишээлбэл, сургуулийн хоолон дээр миний хувьд ийм зарчмын саналтай байдаг.

Сургуулийн захирал нь ямар компаниар хоолоо хийлгэх вэ гэдгээ шийдэж зохион байгуулдаг. Яамнаасаа салаад явсан. Тэр дээр яам нь нэг их оролцоод байгаа зүйл байхгүй. Хууль нь байгаа. Хэрэгжүүлье гэдэг шаардлагыгаа сургуулийн захирлуудад тавьж байгаа.

Гэхдээ тэр энэ дээр нэг их оролцмооргүй байгаа юм. Сургуулийн захирал ч гэсэн өөрсдөө оролцмооргүй байна. Эцэг, эхийн зөвлөл гэдэг байгаа. Эцэг, эхийн хурал гэдэг зүйл улирал болгоноор хийж байгаа.

Тэгэхээр эцэг, эхийн зөвлөлөөсөө өөрсдөө сургуульд сурч байгаа миний хүүхдийн хоолыг энэ байгууллагаас нь авмаар байна. Тэр зохион байгуулах ажлыг нь эцэг, эхийн зөвлөлдөө өгье гэдэг шийдвэрийг эндээс бүгдээрээ хамтдаа гаргаад явах юм бол манай Монголын хүүхдүүд маань бүгдээрээ эрүүл, аюулгүй хоол, баяжсан хүнс идээд илүү өндөр болдог, сурлага нь илүү сайжирдаг.

Багшлы багшийн хөгжлийн тухай ч гэсэн адилхан. Багш нар хэцүү байна гэдэг зүйлийг ярьж байгаа. Гэхдээ нэгэнт бид боловсролтой хүмүүс асуудал ярих гэж байгаа бол шийдлийг нь хамтад нь ярьдаг баймаар байна. Багшийн хөгжлийг дэмжихэд юу дутуу байгаа юм, ямар асуудал тулгарч байгаа юм бэ гэдгийг нь энд Өргөдлийн байнгын хороон дээрээ бүгдээрээ хамтдаа шийдлээ ярилцаад явъя гэсэн ийм санал юм болов уу гэж би бодож байна.

Тэгээд миний хувьд энэ гаргаж байгаа саналыг нь дэмжиж үг хэлж байна. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Дэмжиж үг хэллээ.

Сонгобайн Замира гишүүн микрофоныг өгье.

**С.Замира:** Баярлалаа. Ж.Галбадрах гишүүний оруулж ирж байгаа хоёр асуудлыг дэмжиж байна.

Сургуулийн үдийн хоол асуудалтай гэдгийг бүх хүмүүс мэднэ. Тэгэхдээ энд сургуулийн үдийн хоол ч байя, цэцэрлэгийн хоол ч байя ер нь нэгдсэн нэг стандарт гэж байдаг юм уу? Манай Монгол оронд. Нэгдүгээрт ийм байгаа.

Хоёрдугаарт, үзэмжээрээ тэр сургуулийн захирал, захиргаа нь, тэгээд эцэг, эхийн зөвлөл гээд өөрснөө бизнес болгосон. Үүнийг. Ийм баймааргүй байна. Энэ тал дээр бид хэрвээ хяналт шалгалт хийхээр байвал оруулж ирж байгаа асуудлыг нь батлаад хяналт шалгалт хиймээр байвал үүнийг нэг мөр болгох ёстой гэж бодож байна.

Ер нь энэ тал дээр хийсэн ер нь судалгаа байгаа юу? Танд. Тэрнийг тодруулъя.

**О.Номинчимэг:** Жанчивын Галбадрах гишүүн хариулъя.

**Ж.Галбадрах:** Баярлалаа. С.Замира гишүүнд. Стандарт ер нь байгаа.

Тэгээд стандартыг миний түрүүний хэлээд байгаа –

— сумын сургууль дээр яваад очихоор,

---

- аймгийн сургууль дээр яваад очихоор,
- хотын захын сургууль дээр яваад очихоор,
- хотын төвийн сургууль дээр бүгдээрээ өөр өөр.

Өөрсдийн засаг захиргааны нэгж дээр хийж байгаа дээр нийтлэг юмнууд байгаа байх.

Тэгэхээр энэ талынхыг нь бид гаргаж ирж, өнөөдрийн хяналт шалгалтаар тэр стандарт нь үнэхээр хэр мөрдөгдөж байгаа юм.

Хоёр дахь таны асуудал дээр үнэхээр бизнес болгоод байна уу гэдэг энэ асуудлуудыг бид яг энэ хяналт шалгалт. Бидэнд хий хоосон гэдэг юм уу, ер нь бодитой кэйсүүд зөндөө байгаа л даа. Тийм хардлага, тийм бодит хийж байгаад алдаа оноонд орсон захирлууд, сургуулийн удирдлагууд байдаг.

Тэгэхээр бид үүнийгээ гаргаж ирээд явал энэ бизнес болохгүй байх юм, явал стандарт нь алдагдахгүй байх юм бэ гэдгийгээ бид гаргаж ирж хэлж явах нь энэ үр дүнд л бид гаргах юм.

Тэгээд “үр дагаврын үнэлгээ” гэдэг юм уу, үүнийхээ үр дүнд бид энэ зүйлийгээ гаргана.

Би яг одоогоор нарийн судлаад хэчнээн ямар байгаа юм гэсэн тийм сургуулиуд дээрээс судалгаа авсан юм алга. Энэ маань хэрвээ батлагдаад явах юм бол тэр хариуц хүсэж байгаа Боловсролын ерөнхий газраас нь юм уу, яамнаас нь юм уу энэ хоол эрхлэлтийг хийж байгаа тэр холбогдох газруудаас нь судалгаанууд аваад явна.

**О.Номинчимэг:** Энэ асуудалтай холбоотой нэгдүгээрт хэлбэрийг нь Та хэлээч.

- Үр дагаврын үнэлгээ хийх гээд байна уу?
- Мэдээлэл, тайлангаа сонсох гээд байна уу?

Хүүхдийн сургуулийн шим тэжээл, хоолтой холбоотой асуудал дээр Улсын Их Хурлын дахь эмэгтэй гишүүд маш их анхаарч байгаа. Олон санаачилга гараад өчигдөр зарим эмэгтэй гишүүд, А.Ундраа гишүүн зохион байгуулаад ШУТИС дээр очиж энэ асуудлаар ярилцсан.

Өргөдлийн байнгын хороон дээр ерөнхий боловсролын сургуулийн хоол, шим тэжээлийн арга зүйч, энэ хүмүүсийг байнга сургалтад хамруулахгүй бол зүгээр л манай Ц.Мөнхтуяа гишүүний хэлж байгаа шиг амт шимт муутай. Тийм ээ. Арга зүйгээ харахгүй бол хэцүү байна. Энэ дээр нь тэр хууль эрх зүйн зохицуулалт, төсөв мөнгөнийх нь зориулалтыг оруулж өгөөч гэдэг өргөдөл ирсэн.

Хоёрдугаарт, эхний шатын судалгаагаар миний мэдэж байгаагаар хүүхдийн хоолонд хуваарилж өгч байгаа төсвийн 40 хувь нь хоолондоо очихгүй байна, шал өөр юманд зарцуулагдаж байна. Зөвхөн 60 хувь нь л хүүхдийнхээ хоол болж очиж байна гэдэг судалгаа гарсан байгаа.

Нийслэл дээр ажиллаж байх ч ШУТИС-тай хамтраад иргэдийн төлөөлөгч нараас бүрдсэн ажлын хэсэг ажиллаад юун дээрээ асуудал байна гэдгийг олон талаас нь харсан.

Тэгэхээр энэ дээр бид ахиц дэвшил гаргах, яагаад мөнгөнийх нь 40 хувь нь хүүхдүүддээ очихгүй өөр юманд очоод байна гэдэг дээр. Үүнийг л сайжруулах юмыг Ц.Мөнхтуяа гишүүн хүсээд байх шиг байна. Бидний хувьд ч гэсэн энэ эхний зорилго байх ёстой.

Тэгээд дараа дараагийн шим тэжээлийн нэмэгдэх тэр дунд, ахлах сургуулийн сургуулийнханд үдийн хоолтой болох асуудал дээр анхаарах ёстой. Тамхины хяналтын тухай хуулиар бид тамхинаас орж ирж байгаа татварыг ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн шим тэжээлтэй хоолонд зарцуулъя, хүүхдүүдийн спорт, дугуйланд зарцуулъя гэдэг хоёр концепцыг оруулж ирсэн.

Тэгээд бүгд тал талаасаа тогтолцооны хувьд хаана хаанаас нь дэмжлэгтэй үүнийг явуулмаар байна. Гэхдээ асуудал нь хаана байна гэдгийг тодорхойлж гаргаж ирээд засах юмыг хийх дээр санал нэг байгаа.

Тэгээд нэгдүгээрт Ж.Галбадрах гишүүнээс асууж байгаа нь тайлан мэдээлэл сонсох байдлаар явахад окэй юм уу?

Хоёрдугаарт, О.Саранчулуун гишүүн үүнтэй холбоотой хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг гээд санал явсан. Энэ хоёрыг нэгтгээд аятайхан явуулсан нь хүч тарамдахгүй байсан нь дээр үү? Гэхдээ саналаа хэлээрэй. О.Саранчулуун гишүүнийх хүнсний аюулгүй байдал гээд нэлээн том хүрээ байгаа болохоор нэгтгэх үү, яах вэ гэдэг дээр та хэдийн саналыг сонсмоор байна.

Хоёрдугаарт, хэлбэрийг нь сонсмоор байна.

Гуравдугаарт, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт гээд.

Энэ дээр үр дагаврын үнэлгээ л байх болов уу л гэж бодож байна шүү дээ. Энэ хийгдсэн юм уу, үгүй юм уу? Хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг нь эхлээд харж байгаад үр дүнтэй хууль байсан байна уу, үгүй байна уу, юун дээр байна гэдгийг нь харах гэж байгаа байх гэж ойлгож байна. Зөв үү?

---



Ж.Галбадрах гишүүний хариултыг.

**Ж.Галбадрах:** Баярлалаа.

Тэгэхээр хэлбэрийн хувьд мэдээлэл тайлан сонсьё, бас хэлэлцүүлэг хийе. Сайхан сайхан туршлагууд их байдаг л даа.

Тэгэхээр тэр сайхан туршлагуудыг нь бүгдээрээ гаргаж ирээд, түгээж дэлгэрүүлж, бусад сургуулиудад жишиг болгох талаас нь тийм хэлэлцүүлгийг хийе.

Тэгээд ер нь хоёулан дээр нь би “үр дагаврын үнэлгээ” хийлгэх, тэр байтугай олон гишүүд энэ асуудлыг ярьдаг. Та ч сая хэлж байна. Ялангуяа эмэгтэй гишүүд дэмждэг. Энэ дээр бүгдээрээ боломжтой байдаг бол тийм ажлын хэсэг гаргаад, дэд ажлын хэсэг гаргаад, тэгээд оролцоод. Тэр ШУТИС дээр хоол үйлдвэрлэлийн талаар мундаг гоё технологитой юмнууд яригдаад явдаг. Тэндээс бид суралцаад, тэрийг түгээгээд, зөвлөмжүүд гаргаад явах.

Боловсролын ерөнхий газраас судалгаатай, дээрээс нь зөвлөмж, хоолны илчлэгийн талаар хэр явж ирсэн юм гэдэг товхимол хүртэл гарсан байдаг л даа.

Бүгдээрээ үүнийгээ хараад. Тэр байтугай бид чинь сая төсөв дээр дунд ахлах ангийнханд хүртэл өдрийн хоолыг нь өгөх төсвийг манай Р.Сэддорж гишүүн санаачлаад гаргаж байсан.

Ийм маягаар бүгдээрээ энэ дээр анхаарлаа хандуулаад явахад би үр дагаврын үнэлгээг нь хийлгээд, сайн туршлагуудыг нь гаргаад, хэлэлцүүлэг хийгээд явах ажлын хэсэг гаргах ийм л саналтай байна.

Тэгээд боломжтой байдаг бол О.Саранчулуун гишүүн хэлэх байх. О.Саранчулуун гишүүн бид нийлүүлээд нэгдсэн байдлаар явахад ч надад татгалзаад байх зүйл байхгүй.

**О.Номинчимэг:** О.Саранчулуун гишүүн байр сууриа илрүүлэх үү. О.Саранчулуун гишүүний микрофоныг өгөөдхөөч.

**О.Саранчулуун:** Манай дээр цэцэрлэг, сургууль, дотуур байр гээд яг хүүхдийн сурч байгаа орчинтой холбоотой хоол хүүхдийн аманд орох хүртэлх замыг бид нэг бүрчлэн яримаар байна.

Тэгэхээр гадаадаас юм уу, юу гэдэг юм –

- экспорт, импортын хүнсний асуудал дээр бид дүрэм журамтай.
  - Хүнсээ тээвэрлэх асуудал дээр дүрэм журамтай.
-



- Ямар хүнс авах юм.
- Шошго, хаяг нь ямар байх юм.
- Хадгалалт хамгаалалт нь ямар юм гэдэг дээр дүрэм журамтай.

Хоолны хадгалалт буюу сургуулийн агуулах, гал тогоо гэхээр дүрэм журамтай.

Бидэнд юун дээр дүрэм журам байхгүй болоод байгаа гээч. Нэг ангид сууж байгаа 10, 20 хүүхдэд –

- хоолыг аяганд нь ямар халбагаар хутгаж өгөх юм,
- хоол идэх цагийг нь яаж гаргаж өгөх юм,
- хүүхэд болгонд хоолыг идүүлэхийн тулд ямар дадал зуршлыг гаргаж, орчин бүрдүүлж өгөх юм –

-гэдэг ямар ч дүрэм журам байхгүй.

Тэгээд ямар ч зааваргүй байгаа. Ер нь ихэнхдээ тийм.

Тийм учраас хэлээд байгаа байхгүй юу. Хэчнээн Д амин дэмтэй сүү, хэчнээн баяжуулсан гурилаар хоол унд хэчнээн чанартай хайрцгаар зөөж ирээд, хэчнээн супер унаагаар зөөж ирсэн ч хүүхэд тэр хоолыг идэхгүй байна гэдгийг бид хармаар байгаа байхгүй юу.

Энэ бол эрүүл мэндийн зан үйл юм. Эрүүл мэндийн дадал байхгүй юу. Бид өнөөдрийг хүртэл эрүүл мэндийн дадал зуршлыг хувь хүний ухамсарт даатгаад орхисон байгаа. Ухамсраараа өөрөө үүнийгээ хийх байх, ээж аав нь заагаад өгөх байх гэж байна.

Өнөөдөр 14.00 цаг болж байна. Бид өдрийн хоолоо идэж амжаагүй энд хурлаас хурлын урд сууж байгаа. Монголчууд бүгдээрээ хоол унд идэх тэр хувь хүний эрүүл мэндийн дадал зуршил дээр угаасаа суугаагүй, дадаагүй.

**О.Номинчимэг:** Нийлүүлэх нь дээр юм уу, тусдаа байсан нь дээр гээд байгаа юм уу? Тэр дээр л саналаа хэлчих. Тэгэх үү.

**О.Саранчулуун:** Тусдаа байлгаад яг энэ орчин нөхцөлийн асуудал руу илүү анхаарах гээд байгаа байхгүй юу даа.

**О.Номинчимэг:** Ойлголоо. Тэгвэл тусдаа байлгах юм байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл дээр Ж.Галбадрах гишүүн юу гэлээ? Үр дагавар хийлгэх гээд байгаа юм уу, эсвэл ажлын хэсэг

---

байгуулж байгаад мэдээлэл тайлангаа сонсох гээд байна уу? Тусдаа. Нэг л аргаар бид цаглаварт саналаа өгнө шүү дээ.

Окэй. Ингээд Жанчивын Галбадрах гишүүний гаргасан 2 саналаар санал хураалт явуулъя.

Нэгдүгээр асуудал. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулах, тайлан мэдээлэл сонсох хяналт шалгалтыг цаглаварт оруулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийлгэх, хянан шалгалтын цаглаварт оруулах саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Жанчивын Галбадрах гишүүнээс гаргасан хоёр санал дэмжигдлээ.

Хамгийн сүүлд миний гаргасан санал байгаа. Би эхний ээлжид хоёр санал гарсан боловч нэгийг нь татъя гэж бодож байна.

Мэргэжлийн Байнгын хороотой зөвлөлдөж байгаад хуулийн хэрэгжилт дээр хангалттай хугацаа гараагүй байгаа учраас ямар хэлбэрээр байх вэ гэдгийг дараа шийдэх байдлаар Хүний хөгжлийн байнгын хороотой зөвшилцөж байж энэ асуудлыг цааш нь явуулъя гэж бодож байна.

Тэгэхээр надаас нэг л санал байгаа. Ер нь иргэдээс ирж байгаа маш их өргөдөл, гомдол байгаа юм. Тэрний нэг асуудал та бүхний ч гэсэн ойр тойрны хамаатан садан, таньдаг хүмүүст чинь бүгдээрэнд нь л тулгарч байгаа асуудал. Орон сууц захиалах болон худалдан авах харилцаатай холбоотой.

Иргэд шинээр орон сууц захиалахдаа дөнгөж баригдаж байгаа барилгад захиалагч болоод урьдчилгаа 20-иос 30 хувь төлдөг. Энэ жилийн сүүлээр орно, тэр жилийн тэддүгээр улиралд орно гэдэг гэрээ хийдэг боловч ачир дээрээ энэ хугацаа маш удааширдаг.

Тэгээд урьдчилгаа мөнгийг нь аваад 2 жил, 3 жил болсон, 5 жил, 6 жил болоод мөнгөө алдсан, эсвэл орж чадахгүй байгаа нэг ийм ацан шалаанд орсон. Хэрэглэгч талаасаа ч гэсэн хохироод байгаа хэргүүд маш их байдаг. Барилгын ажлууд, орон сууцууд цагтаа ордоггүй. Орсон ч тэр нь чанарын шаардлага хангадаггүй.

Тэгээд захиалагчийн өгсөн мөнгийг нөгөө барилгаа барихад биш шал өөр юманд эргэлдүүлж эргэлдүүлж байгаад барилгаа нэлээн хойшлуулж байгаад нэг оруулдаг ч юм байгаа. Яг энэ хооронд мөнгөний үнэ цэн нь ч буурсан байдаг. Захиалга өгсөн иргэдийн хувьд ч гэсэн орон сууцдаа орж чадахгүй эрх нь зөрчигдөөд байгаа асуудлууд маш их байгаа. Одоо ч үргэлжилж байгаа.

Тэгэхээр энэ асуудлаар Өргөдлийн байнгын хороонд олон асуудал тавигдаж ирсэн.

Тэгэхээр энэ нэгхэн хуулийн асуудал биш энэ өөрөө олон салбар хуулиуд хоорондоо байна уу, эсвэл хуулийн механизм байхгүй байна уу. Ер нь барилгын захиалагчийн дундын хяналт гэдэг юм манай хууль дээр ерөөсөө алга байна. Бид эхний шатад үүнийг хууль тогтоомжийн хүрээнд шат алгахаар үнэхээр гэрээгээрээ л болно биз гээд хаядаг.

Хууль тогтоомжийн хүрээнд энд хэрэглэгч талаас нь хамгаалсан, дундын хяналтын механизм байхгүй. Гэрээн дээрээ ёстой нэг талын гэрээ гэдэгчлэн юм байгаад гэрээгээрээ ийм шүү дээ гээд алга болж байгаа юм байна.

Тэгэхээр энэ асуудлыг бид хэлэлцэж бодлогын шийдэл юу байх ёстой вэ гэдэг дээр нэг шийдэл гаргах ёстой байна.

Тэгэхээр орон сууц захиалах, худалдан авах харилцаан дахь хууль тогтоомжийн хэрэгжилт, хийдэлтэй холбоотойгоор мэдээлэл сонсож, тайлан илтгэлийг хэлэлцүүлж эндээс бид бодлогын шийдэл гаргая гэсэн саналаар хянан шалгалтын цаглаварт тусгах саналтай байгаа.

Энэ саналтай холбоотойгоор гишүүдээс асуулт асуух, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү?

Гишүүдийн санал орохгүй байна гэж байна. Асуулт асуух, санал хэлэх гишүүд одоо орж байна.

С.Замира гишүүнээр тасаллаа. 4 гишүүнээр тасаллаа.

Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт, асууж үг хэлье. О.Саранчулуун гишүүнийг нэмээрэй.

**Г.Лувсанжамц:** О.Номинчимэг гишүүний саналыг дэмжиж үг хэлье.

Яалт ч үгүй гэрээ хийхээр нэг талаа баримталсан буюу аж ахуйн нэгж нь өөрөө давуу талтайгаар гэрээ хийдэг. Иргэн өөрөө хэрвээ ямар нэгэн боломжгүй байдлаас болоод төлбөрөө хоцроосон ч юм уу, тийм нөхцөл гарахаар алданги

тооцоод эхэлдэг. Тэгээд барилгын компани ашиглалтад оруулаагүй хоёр, гурван жил алга болсон мөртлөө алданги тооцдоггүй.

Тэгэхээр хэтэрхий нэг талын давуу байдлыг барьсан тийм нөхцөл байдалтай байгаа учраас үүнийг нь мэдээллийг нь сонсож байгаад шийдэл гаргая гэж байгаа нь дэмжиж байна.

Хоёрдугаарт нь, Барилгын хөгжлийн төв, Хот байгуулалтын яам дээр, эсвэл нийслэл дээр ч юм уу энэ баригдаж байгаа барилгуудын мэдээллийг ил болгох хэрэгтэй.

Ямар аж ахуйн нэгж хэрэгжүүлж байгаа юм, зураг төслийг нь хэн зурсан юм, тооцоог нь хэн гаргасан юм.

Тэгээд иргэд эндээсээ ороод мэдээлэл нь байх юм бол орон сууцаа захиалдаг, байраа захиалдаг. Тийм ээ. Тийм байдлаар яваад төр нь өөрөө мэдээллийг ил тод болгоод бүртгэдэг тогтолцоондоо орохгүй бол зарим тохиолдолд аж ахуйн нэгжүүд өөрсдөө төрөөсөө хамаараад барилга нь ашиглалтад орохгүй удаад байдаг. Зураг төслийн магадлан, улсын комисс ажиллах гээд. Шалтгаангүйгээр хурал нь хойшлогдоод яваад байдаг тийм зүйлүүдийг нь тодорхой болгож өгөх юм бол энэ үүсээд байгаа нөхцөл байдлыг арилгах боломж нь байгаа болов уу.

Тэгээд энэ саналыг дэмжиж байна.

**О.Номинчимэг:** Дэмжиж үг хэллээ. Баярлалаа. Энэ бол яалт ч үгүй орон сууцад оръё, орон сууцаа томруулъя гэж хүсэж байгаа олон иргэдэд учирч байгаа бодит бэрхшээл байгаа.

Тэгээд энэ дээр хууль нь үнэхээр байна уу гэхээр аягүй олон хуулийн дунд байдаг юм билээ.

Тэгэхээр нэлээн том сууриар нь хараад асуудал нь юу байна, хөшүүргүүдийг яаж хийх вэ гэдэг дээр бид хаврын чуулганаар сайн хамтдаа Өргөдлийн байнгын хороо ажиллаад шийдэлтэй байя гэсэн зорилготой байгаа.

Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн.

**Ц.Мөнхтуяа:** Энэ их маш чухал санал байна.

О.Номинчимэг гишүүний гаргаж байгаа санал. Би л нэг кэйс ярих гэж байна. 2020 онд багш нарыг орон сууцжуулна гээд Монголын багш нарын “Шинэ зуун” зөвлөлдөх зөвлөл “Ногоон хөгжил” гээд компанитай нийлээд мянга гаруй багшийг орон сууцад оруулна гэсэн нэрийдлээр. Энэ дээр зөвхөн багш биш бас эрүүл

---

мэндийн салбарынхан орсон байгаа юм. Соёл, урлагийн салбарынхан орсон байгаа юм. Ингээд бараг 3, 4 мянган хүний хохиролтой, 10 гаруй тэрбум төгрөг бараг болсон гэж яриад байгаа байхгүй юу.

Тэгээд эндээс мянга гаруй манай багш нар нэлээн олноороо орсон.

Тэгээд энэ хэргийг Сүхбаатар дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтэс дээр өргөдөл, гомдлоо өгөөд шалгуулахаар хэрэгсэхгүй хаяад байна. Ц.Мөнхтуяа гишүүн ээ, энэ дээр Та дуугараач гэсэн юм.

Тэгээд би хаашаа дуугарахаа мэдэхгүй явж байгаад өнөөдөр харин О.Номинчимэг гишүүн маань яг гоё загатнасан газар маажна гэдэг шиг маш зөв санал оруулж ирлээ.

Тэгээд үүнийг би бас энэ Монголын багш нарын төлөөлөл болж энэ Их Хуралд сууж байгаа гишүүний хувьд О.Номинчимэг гишүүнтэйгээ хамтраад энэ “Ногоон хөгжил” гэдэг энэ луйвар залилангийн компанийг Өргөдлийн байнгын хорооноосоо бүр юу яагаад цагдаагийн 1 дүгээр хэлтэс дээр өгсөн тэр багш нарын санал гомдлыг татаад үүнийг бүр нэг ажил болгомоор байна.

Энэ бол маш олон хохирогчтой. Тэгээд зарим нь хөөрхий амьтан хүртэл мөнгөө өгөөд явж байгаа юм шиг байгаа юм.

Тэгэхээр үүнийг бүр цэгцлэхгүй бол энэ “Ногоон хөгжил” гэдэг компани ямар ч барилга бариагүй, бүр үүнийг надтай холбож хүртэл миний нэр хүндийг унагааж байсан ийм кэйс явж байсан шүү дээ. 2023, 2024 оны үед.

Тэгээд энэ “Ногоон хөгжил” компанийг багш нарын “Шинэ зуун” зөвлөлдөх зөвлөл гээд хоёр байгууллагыг би шалгуулна. Одоо ёстой гоё момент гарч ирлээ. О.Номинчимэг гишүүндээ баярлалаа. Энэ дээр би бүр яг ажиллана. Тултал явна шүү. Ийм байна.

**О.Номинчимэг:** Саналыг хүлээж авлаа. Бид яг л энэ иргэддээ тулгарч байгаа энэ асуудлуудыг шийдэхдээ хууль эрх зүйн хүрээнд хийдэлтэй байна уу гэдгийг нь гаргаж ирэх ёстой байгаа.

Тэгээд барилгын захиалга өгөөд уддаг ч тохиолдол байна. Барилгын компани нь алга болдог ч компани байна. Тийм залилангийн шинж чанартай, урьдчилгаа мөнгөө өгөөд хохироод үлдсэн иргэд ч байгаа. Тийм. Давхардуулж зарж байгаа ч асуудал байгаа.

Тэгэхээр барилгын компаниудын үүрэг хариуцлага, стандарт хэрэгжилт дээр бид яаж анхаарах юм. Ил тод байдлыг ар нь шахаж бид юу хийх ёстой юм

---

гэдэг асуудлыг үнэхээр гаргаж тавихгүй болохоо байсан гэдэг дээр олон гишүүд санал нэгдэж байгаад баярлалаа.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

**С.Эрдэнэбат:** Маш чухал асуудал. Яг дундын хяналт шалгалтын юм орхигддог. Маш олон иргэдийн мөнгөн дээр нь тоглодог. Миний мэдэхийн л лав хэдэн мянгаараа хохирсон, яахаа мэдэхгүй, шүүх нь 4, 5, 6 жил болдог.

Тэгээд үндсэндээ нэг хэсэг бүлэг хүмүүс нэг ял аваад, тэгээд тэр нь өршөөлгөх гэдэг юм уу, эсвэл хойшлуулъя гэдэг шалтгаанаар бүр сурсан хэдэн хүмүүс байж байгаа.

Тийм учраас энэ тал дээр хяналт шалгалт хийхээс гадна ажлын хэсэг байгуулаад, яг Улаанбаатар хотод баригдаж байгаа, баригдах гэж байгаа гоё гоё зураг үзүүлдэг, модель үзүүлдэг. Яг үнэнийг хэлэхэд манай барилгын 70 хувь нь ногоон байгууламж байх юм гэж байгаад яг мөнгийг нь авсаны дараа ашиглалтад ороод ирэхийн цагт урд талд нь том том оффисууд барьдаг. Тийм ээ.

Энэ мэтчилэн ийм зүйлийг ерөөсөө цахимжуулах хэрэгтэй байгаа. Иргэдэд өнөөдөр байраа захиж байхад бараг загварын гэрээ гэдгийг нь хүртэл хэрэглэгчийн төлөө газар хянах зүйлийг нь хэлмээр байгаа юм.

Тийм учраас энэ зүйлийг маш сайн дэмжмээр байна. Аль аль чиглэл арга хэрэгслийнх нь хувьд ч гэсэн ажлын хэсэг ч байгуулах, үзэх, яг байр авах гэж байгаа болон хохирсон иргэдтэй уулзах, бид нарын олж хараагүй ч гэсэн маш олон хүмүүс яахаа мэдэхгүй л яваад байгаа байх. Шүүхээр л голцуу явж байгаа байх.

Дээрээс нь санал хэлэхэд захиалах, худалдан авахаас гадна орон сууц бариад конторыг нь давхар авдаг. Тийм ээ. Тэгээд дээрээс нь СӨХ-г нь авдаг гээд манай энэ барилгын компаниуд чинь зарим нь монопол байдлаа ашиглаад давхар давхар бизнес, сүлжээ үүсгээд шийддэг. СӨХ-той холбоотой маш их санал гомдол ирэх юм. Бараг 10, 20 жил болчихоод нэг ч удаа хурлаа хийгээгүй, тайлангаа тавиагүй, яриагүй ийм СӨХ. Тэгээд СӨХ-ны тухай хуулиар тодорхой хэмжээний юу хийе гэж байсан. Давхар энэ барилгын захиалагч, контор юу гэдэг юмыг ер нь цаашдаа нэг үзэд гэмгүй юм шиг байгаа юм.

Тийм учраас орон сууц захиалах, худалдан авах харилцаан дахь хууль тогтоомжийн асуудлыг хянан шалгаад, шаардлагатай бол зохицуулалтуудыг нь хийх.

Шүүхийн процесс дээр явж байгаа кэйсүүдтэй танилцмаар юм шиг байна лээ. Иргэдийг сэрэмжлүүлэх зорилгоор. Гэрээний нэг талын давамгай гэрээгээр.

---

Иргэд бол очоод л гарын үсэг зурж байгаа шүү дээ. Санал ч хэлэх эрх байхгүй. Ийм зүйлүүдийг уг хяналт шалгалтын хүрээнд жоохон өргөжүүлээд, яг үнэнийг хэлэхэд маш том орон зай үлдсэн зүйлүүд байгаа.

Түрүүн Г.Лувсанжамц гишүүний хэлдэг шиг энд ийм барилга баригдана, зөвшөөрөл нь гарсан, гараагүй, ер нь техникийн боломж авах боломжтой юм уу, үгүй юм уу гэх мэтчилэн маш олон зүйлийг хүн интернэтээр ороод л хардаг ийм зүйл дээр нь хяналт шалгалтаа хийвэл илүү үр дүнтэй байх болов уу гэж бодож байна. Ингээд дэмжиж байна. Уг саналыг.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Саналуудыг цаашдын ажилд тусгаад явъя.

Сонгобайн Замира гишүүн.

**С.Замира:** Баярлалаа. Энэ маш чухал асуудал оруулж ирсэн байна. О.Номинчимэг гишүүн. Дэмжиж байна.

Орон сууцын асуудал маргаанд орсон, хохирсон иргэд их байгаа шүү дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ипотекийн зээл гээд ард түмнийг мөлжиж байгаа нэг хэсэг байна. Тэр чинь залуучууд нэг, хоёр өрөө байр аваад 40 хэдэн сая төгрөгийн байрыг хоёр, гурав нугалж насан туршийн өр зээлтэй үлдэж байна гээд маш их гомдол гараад байгаа шүү дээ.

Яг энэ хяналт шалгалтын үеэр ипотекийн зээлийн асуудал хөндөгдөх үү? Байр өгч, авч байгаа асуудлыг нь бид тайланг нь сонсож, энэ дээр хяналт оруулах боломж байгаа юу? Үүнийг тодруулах гэсэн юм.

**О.Номинчимэг:** С.Замиран гишүүний асуултын хувьд ипотекийн зээлийн хувьд зээлд ороод захиалгаа өгөөд, тэгээд тэр нь хойшлоод байгаа асуудал дээр холбогдох байх. Тэр дээр давхцал байгаа байх.

Түүнээс ипотекийн зээлийн хүртээмж өөрөө хэр байна, яагаад ийм хүртээмж муутай байна гэдэг асуудал арай жоохон өөр төрийн бодлогын асуудал болоод явна.

Энэ хяналт шалгалтын ажил бол ерөөсөө барилгын компани болон захиалагч, иргэд хоорондын харилцаан дээр яагаад ийм гажуудал гараад, барилгын компанийн хариуцлагагүй байдлыг өөгшүүлсэн, хэрэглэгч захиалга өгсөн иргэдийн эрхийг зөрчиж санхүүгийн хувьд ч гэсэн, амьдрах нөхцөлийн хувьд ч гэсэн зөрчигдөөд хойшлоод байдаг асуудал дээр бид хууль эрх зүйн ямар ч хөшүүрэг байхгүй. Гэрээний эрх зүй гэдэг юмаар яваад байна уу, яах ёстой вэ



гэдэг дээр нэг шийдэл орж дахиж ийм олон хүмүүс мөнгө төгрөгөө барилгад захиалга өгчхөөд хохирч үлдэхгүй байхад л энэ асуудлыг хэлж байгаа.

Тэгэхээр тэр хүрээний асуудал байгаа. Ипотекийн зээлийн хүртээмжийн талаар байдаг юм уу, эсвэл очер дарааллын талаар яаж явж байна гэдэг асуудал арай тусдаа бодлогын асуудал. Тийм ээ. Төрийн байгууллагатай холбоотой байх. Тэр дээр ажлын хэсэг байгаа гэдгийг Эдийн засгийн байнгын хороон дээр байх. Тийм үү. Гарсан байгаа юм байна гэдгийг хэлье.

С.Замира гишүүн.

**С.Замира:** Энэ асуудал дээр гол ярьж байгаа асуудал нь 40 сая төгрөг, 50 сая төгрөгийн 2 өрөө байр нь хоёр, гурав дахин нугалж байгаа. 120 сая, 150 сая гээд маш их үнэтэй ард түмэнд хүрч байгаа гэсэн гомдол байгаа шүү дээ. Ард түмэнд. Энэ нь маш удаан жил тэрний зээлийг нь төлнө. Өр зээл насан туршид нэг, хоёр өрөө байр авсны төлөө насан туршийн өр зээлтэй болж байна гэсэн.

Үүнийг цэгцлэх боломж ер нь манай төр засагт байна уу? Бид тэр юун дээр орж чадах уу гээд асууж байна.

**О.Номинчимэг:** Эдийн засгийн байнгын хороон дээр явж байгаа асуудлуудаас асуусан асуулт байна. Тийм ээ. Тэр төрийн бодлого тэгвэл яах ёстой юм бэ гэдгийг та тэр Байнгын хороон дээр саналаа гаргаад явахыг хүсье.

Отгоны Саранчулуун гишүүн.

**О.Саранчулуун:** Баярлалаа. Энэ асуудлыг дэмжиж байгаа. Тэгэхдээ илүү нарийвчлан оролцох ёстой асуудал нь байр орон сууц худалдан авахаар татварын буцаалт авдаг. Тийм ээ.

Тэгээд тэр дээр татвар төлөөд, нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэр асуудал үйлчилдэггүй байхгүй юу. Тэгээд тэр жишээлбэл яг олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ирдэг асуудал учраас үүнийг бид энэ асуудлаар хянаж ярих ёстой байх гэж үзээд байгаа.

Хоёрт гэвэл сая бид таван жилийн төлөвлөгөө болон улсын төсөв дээр ер нь түгээмэл загварыг оруулна гээд ярьж байгаа.

Тэгэхээр түгээмэл загвар гэдэг чинь хүн халтирч унадаггүй, гэмтэж бэртдэггүй, хаалга үүд, шат, орц гарц нь бүгдээрээ л хэн ч явсан аюулгүй байх ёстой орчин.

Гэтэл өнөөдөр ашиглалтад орохоор захиалга авч байгаа орон сууцын байшингууд байгаа. 2026 оны тэдэн сард ашиглалтад орно, 2027 он гээд



хуваариа гаргасан. Тэр байшингууд өнөөдөр түгээмэл загвараа хангаж байгаа юу, үгүй юу гэдэг дээр тодорхой биш байгаад байна.

Тэгэхээр үүнийг илүү тодруулж ярих учраас би энэ саналыг дэмжээд энд анхаарах хэрэгтэй гэж үзээд байгаа.

Гуравт нь, үер болсон шүү дээ. Өнгөрсөн жил. 2 жилийн өмнө. Тийм ээ. Үер болоод бид үерийн бүсэд байшин, барилга барихтай холбоотой бүх нийтээрээ ямар их хохирол амссан билээ. Гэтэл тэнд нь байшин барилгууд баригдаад дахиад иргэдийн захиалгыг аваад явж байгаа жишээтэй. Тийм ээ. Энэ дээр ер нь ямар хяналт тавьдаг юм. Иргэд үүнийг худалдаж авахдаа тухайн үед нь дахиад л мэдэхгүй. Үерийн үеэр далантай шүү гэж анхааруулаад байгаа мэдээлэл нь олон нийтэд явдаггүй. Харин гоё байшингийн зураг нь болохоор олон нийтэд яваад байдаг нэг ийм гурван чухал асуудал яг энэ орон сууц захиалж худалдан авах харилцаан дээр заавал нэг ярих ёстой байхгүй юу.

Тэр утгаар нь би энэ саналыг дэмжиж байна.

**О.Номинчимэг:** Баярлалаа. О.Саранчулуун гишүүн дэмжлээ. Саналуудыг цаашдын ажилд тусгаад явъя гэж бодож байна.

Ингээд асуулт асууж, үг хэлэх гишүүд дууслаа. Одоо санал хураалт явуулъя.

Орон сууц захиалах, худалдан авах харилцаан дахь хууль тогтоомжийн хэрэгжилтийн нөхцөл байдлын талаар ажлын хэсэг байгуулж, тайлан мэдээлэл сонсож, хэлэлцүүлэг хийх асуудлыг Хяналт шалгалтын цаглаварт оруулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны гишүүдийн дэмжсэн саналыг Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийгдэх төлөвлөгөөт хянан шалгалтын цаглаварт тусгуулах саналаа Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Ажлын алба болон гишүүддээ баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 31 минут үргэлжилж, 14 цаг 30 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**